MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,130.755... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.02.08. Лхагва. №026 (4640)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ

Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




**УЛС ТӨР**

Н.БASSPTCАЙХАН: ТҮНШ ОРНУУДЫН ТӨВ БАНКУУДТАЙ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТ СОЛИЛЦОХ СВОП ХЭЛЦЭЛ ХИЙНЭ

**II нүүрт**

**ДЭЛХИЙ**

БНХАУ-ЫН АНХНЫ ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ОНГОЦ ТУН УДАХГҮЙ НИСЛЭГ ҮЙЛДЭНЭ

**IV нүүрт**

Дугаарын 60 мөр

## Өвлийн спортынхонд битүү ордон л хэрэгтэй байна

Н.ПУНЦАГБОЛД

Монголчууд багийн спортоор хэзээ ч амжилт гаргахгүй гэж мэдэмхийрдэг хүмүүс манайд олон байсан. Гэтэл манай сагсан бөмбөгийн тамирчид ямархуу амжилт үзүүлж байгаа билээ. Тэр битгий хэл манай хоккейчид ДАШТ-ээс хүрэл медаль хүртээд ирлээ. Мэдээж В ангиллын багуудын ордог тэмцээн л дээ. Гэхдээ тэд чадсан. Мөн манайхан өвлийн спортоор амжилт гаргаж чадахгүй гэж мэдэмхийрэгчид ч бас байдаг. Гэтэл хоккейчид яав. Тэшүүрийнхний амжилт жилээс жил өсч байна. Б.Сумъяа гэдэг охин залуучуудын Олимпийн наадамд түрүүлсэн биз дээ. Бусад улсын тамирчидтай баг болж уралдсан учраас түрүүлсэн гэвд манайхан ач холбогдол өгөхгүй л байгаа болохоос. Ер нь бол жилээс жил тэшүүрийнхний амжилт өсч, улсын рекордыг шинэчилж, дэлхийн шилдгүүдийн хэмжээнд хүрэх зүйл дөхөж л байна. Гэхдээ бид өвлийн Олимпийн наадмаас медаль хүртчихээр хэмжээнд арай хүрээгүй байгаа. Тэр хэмжээнд хүрч, тамирчдын ур чадвар өсөхөд нөлөөлөх нэг зүйл нь байнгын бэлтгэл сургуулилт, хангамж. Мөн дэлхийн жишигт хүрсэн орчинд бэлтгэлээ тасралтгүй хийх хэрэгцээ, шаардлага байгаа. Гэтэл манайд тийм орчин алга.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ

# ЯДУУ МОНГОЛЫН ЯДАРСАН СЭТГЭЛГЭЭГЭЭР ТОГЛОЖ БУЙ G-TIME



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.ОТГОН
Н.БАТЗАЯА

Өглөө ажилдаа ирэхэд л цахим ертөнцийн нэг найз маань “цалингаа хүлээж суухгүй бөөн бөөнөөр нь мөнгө олох арга зааж өгнө” гэх зурвас үлдээсэн байдаг боллоо. Худлаа гэвэл хар би цалингаа авсан гэж ирэхэд л дансанд нь их хэмжээний мөнгө орсон гэх зурвасыг харуулна. Бүр энэ чиглэлийн янз бүрийн фэйсбүүк бүлэгт оруулж “тархи угаах” ажиллагаагаа явуулахыг завдах боллоо. Тэгвэл ганцхан миний танил хүмүүс, найз нөхөд энэ сүлжээний бизнес гэдэг зүйлд “тархиа угаалгаад” байна уу гэвд сонирхож үзтэл үгүй юм байна аа. Өөрөөр хэлбэл, энэ ганцхан миний асуудал биш. Монголын асуудал болчихсон юм байна.

**Үргэлжлэл нь VI-VII нүүрт**

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

## Тэд биднийг “ТАХИА АНХДАГЧ УУ, ӨНДӨГ АНХДАГЧ УУ” гэдэг болох уу гэж байна

Б.ДАВААХҮҮ

Сүүлийн үед “Монголчууд алтан бөгж, аргамаг хүлгээ Засгийн газартаа хандивлаж байна” гэх гарчиг бүхий нийтлэлүүд дэлхийн хэд хэдэн томоохон мэдээллийн сайтад нийтлэгдэж, тэр хэрээр хөрөнгө оруулагчид хийгээд олон улсын анхаарлыг татаж эхэллээ. Ирэх гуравдугаар сарын 21 гэхэд Хөгжлийн банкнаас гаргасан бондын 580 сая ам.долларын эргэн төлөлтөө Монгол Улс ямар арга замаар барагдуулах нь тэдний анхаарлыг зүй ёсоор татаж буй нь мэдээж биз. Тиймээс улс орны эдийн засгийн байдал хийгээд бондын эргэн төлөлтийг Монгол Улс хугацаанд нь төлж барагдуулахтай холбоотой сонирхолтой гаргалгаа, мөн зарим нөхцөл байдлыг үнэлсэн шинжээчдийн үнэлгээ, мэдээллийг энэ удаагийн “Монгол Дэлхийн хэвлэлд” буланараа оруулан хүргэж байна.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ДЭЛХИЙ



## Б.Ассадын дэглэм 13 мянган хүнийг цаазалсан

Б.ДАВАА

Ийм мэдээллийг олон улсын хүний эрхийн Эмнести интернэшнл байгууллага өчигдөр мэдээллээ. Сирийн нийслэл Дамаск хотын зах хэсэгт орших шоронд 2011 оноос хойшхи нийтдээ таван жилийн хугацаанд ихээр бодоход 13 мянган хүн цаазлуулсан гэх мэдээлэл бүхий тайланг тус байгууллага олон нийтэд дэлгэсэн юм. Улмаар “Бөөнөөр устгах” үйл ажиллагаа явуулж байна хэмээн Сирийн Засгийн газрын хүчтэй шүүмжиллээ.

“Хүн нядалгааны газар: Саяднаяа шорон дахь бөөнөөр нь хороох үйл ажиллагаа” хэмээх гарчигтай тус тайланг харгалзагч, хоригдол, шүүгч гэх мэт нийтдээ 84 нүдээр харсан гэрчийн мэдүүлэгт үндэслэн гаргасан байна.

**Үргэлжлэл нь IV нүүрт**




| | ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|
| | АМ.ДОЛЛАР | 2470.00 | 2484.00 | ФУНТ | 3032.00 | 3136.00 |
| | ЕВРО | 2620.00 | 2685.00 | РУБЛЬ | 40.30 | 43.80 |
| | ИЕН | 21.90 | 22.24 | ЮАНЬ | 360.00 | 365.20 |

| | Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|
| | АМ.ДОЛЛАР | 2474.00 | 2486.00 | ФУНТ | 3049.00 | 3147.00 |
| | ЕВРО | 2625.00 | 2711.00 | РУБЛЬ | 40.79 | 44.52 |
| | ИЕН | 21.88 | 22.63 | ЮАНЬ | 360.00 | 365.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

## Н.БАЯРТСАЙХАН: ТҮНШ ОРНУУДЫН ТӨВ БАНКУУДТАЙ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТ СОЛИЛЦОХ СВОП ХЭЛЦЭЛ ХИЙНЭ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.МЯГМАР

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Хөгжлийн банкны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай болон Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийх байлаа. Гэвч УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар Засгийн газар Олон улсын валютын сан /ОУВС/ болон холбогдох хуультай нийцсэн эсэх талаар тодруулга хийх хүртэл уг асуудлыг хэлэлцэхийг хойшлуулах горимын санал гаргав. Уг горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь дэмжих нь зүйтэй гэж үзлээ.

### "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"–ийн төслийг хэлэлцэв

Үргэлжлүүлэн Засгийн газраас өргөн мэдүүлсэн, Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн төслийг хэлэлцээд, гишүүд дэмжиж Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр болов.

Хуралдаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Нямаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр нар оролцлоо. Төслийн танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн хийлээ. Дэлхийн банкны холбогдох удирдлагууд, хуульчидтай зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банктай хамтран ажиллах стратегийн баримт бичгийн хүрээнд тус банкнаас Монгол Улсад хуваарилагдсан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн төслийг хамтран боловсруулжээ. Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацаас Монгол Улсад 2015-2017 онуудад хуваарилагдсан 79 сая ам.долларын зээлийн эх үүсвэр "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-т тусгагдсан байна. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банк хоорондын хамтын ажиллагааны стратегийн баримт бичигт тусгагдсан хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийн дагуу ажил эрхлэлтийг дэмжих, макро эдийн засаг, санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчинг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх, эрчим хүчний түгээх чадавхыг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчээр баруун бүсийн эрчим хүчний хэрэгцээг хангах зэрэг төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр уг хөтөлбөрт тусгажээ.

### ОУВС–гийнхан Монголбанкны тухай хуулийн талаар зөвлөгөө өгчээ

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан оролцож, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай тогтоолын хэрэгжилт, 2017 оны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явцын талаар мэдээлэл хийв.

Монголбанк 2016 онд ТБҮЦ борлуулах болон "Сайн" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын санхүүжилт зэрэгт зориулж зах зээлд 1.5 их наяд төгрөг нийлүүлжээ. Монголбанкны шинэ удирдлагууд хөрөнгийн орох урсгал татарсан үед мөнгө нийлүүлэх арга хэмжээ авсан нь төгрөгийн ханш огцом сулрах үндэс тавигдаж, валютын ханш өссөн гэсэн дүгнэлтэд хүрсэн хэмээн Н.Баяртсайхан мэдээллийнхээ эхэнд онцлов. Тэрбээр, "Миний бие өнгөрсөн оны наймдугаар сард ажлаа хүлээж аваад эдийн засгийг тогтворжуулах, ирээдүйд учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гадаад валютын нөөцийг хамгаалах чиглэлээр бодлогын өөрчлөлт хийсэн. Төсвийн шинж чанартай санхүүжилтийг хязгаарлах, гадаад валютын нөөцийг хамгаалах, төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх, банкны салбарын тогтвортой байдлыг хангах бодлогын цогц арга хэмжээ хэрэгжүүлсэн. Үүнээс өмнө иргэд хадгаламжид байгаа төгрөгөө валютаар солих нь нэмэгдэж байсан. Тиймээс нэн тэргүүнд мөнгөний бодлогын хүүг 4.5 хувиар нэмэгдүүлж, 15 хувьд хүргэсэн. Ингэснээр зээлийн хүү өсөхөөс сэргийлж, төгрөгийн ханшны уналтыг зогсоож чадсан юм. Нөхцөл байдал харьцангуй дээрдсэн үед буюу өнгөрсөн оны арванхоёрдугаар сард мөнгөний бодлогын хүүг нэг хувиар буулгах шийдвэр гаргасан. Дараагаар нь арилжааны банкуудаас Монгол банканд заавал байлгах нөөцийн хүүг жилийн долоон хувьд хүргэлээ. Энэ бүхний үр дүнд үндэсний аж ахуйн нэгжүүдийн экспортын орлого 25 хувиар нэмэгдсэн. Мөн Засгийн газартай хамтран "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр" боловсруулж, УИХ-аар батлуулсан. Энэ хөтөлбөр хэрэгжих шатандаа явж байгаа. Түүнчлэн алт худалдан авах үйл ажиллагааг нээлттэй зохион байгуулж байна. 2016 онд 18.3 тонн алт худалдан авсан бол энэ жил 25 тоннд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Мөн өнгөрсөн онд 660 тэрбум төгрөгийн ипотекийн санхүүжилт олгосон" гэлээ.

Монголбанк 2016 онд нийт 197 удаагийн гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, нэг тэрбум 424 сая ам.доллар, нэг тэрбум 855 сая юаны гүйлгээ хийжээ. Энэ нь сард дунджаар 116 сая ам.долларын арилжаа хийсэн үзүүлэлт юм байна.

Монгол Улс энэ оны гуравдугаар сарын 21-нд 600 сая ам.долларын өр төлнө. Мөн наймдугаар сард БНХАУ-ын Ардын банктай байгуулсан своп хэлэлцээр дуусна. Одоогоор Монгол Улс 1.7 тэрбум ам.доллар авч ашиглаад байгаа аж. Түүнчлэн ирэх оны нэгдүгээр сарын 05-нд Чингис бондын 500 сая ам.долларын төлбөр төлөх ёстой бөгөөд хүү нь 50 сая ам.доллар. Эдгээр өрийг дарахын тулд Монголбанкны валютын нөөцийг хамгаалах чиглэлд гол анхаарлаа хандуулж байгааг мэдээлэлдээ дурьдав. Түүнчлэн, "Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортын голлох түүхий эдийн зах зээлийн төлөв байдлын талаар судалгаа, шинжилгээ хийх зэрэг ажлыг 2017 онд хийхээр төлөвлөж байна. Валютын нөөцийг хамгаалахад алт худалдан авах нь томоохон үүрэг гүйцэтгэнэ. Мөн эдийн засгийн гол түнш орнуудын төв банкуудтай үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцэл хийхээр ажиллаж байгаа. Тухайлбал, ОХУ, БНСУ, Япон улсын Төв банктай хамтран ажиллахаар ярилцаж байгаа ажээ.

Эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай даван туулах бодлого хэрэгжүүлж байна. Засгийн газар, Монголбанк ОУВС-тай хэлэлцээр хийж байгаа. Хэлэлцээрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл авах, санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх, эдийн засгийг эрүүлжүүлэх алхам хийхээр төлөвлөж буй гэнэ. 2017 онд банкны салбарт нилээд чухал ажлууд хийнэ. Нэн тэргүүнд гадаадын банкнуудын үйл ажиллагаа явуулах эрхзүйн орчныг боловсронгуй болгох нь чухал. Саяхан дэлхийд томоохонд тооцогдох Хятадын Худалдаа, аж үйлдвэрлэлийн банкинд Монгол Улсад төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл олгосон. Үндэсний төлбөр тооцооны системийн зохицуулалтын талаар томоохон шинэчлэлийн ажил эхэлж байгаа. Одоо УИХ дээр Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Хуулийг батлснаар төлбөр тооцооны системийг шинэ төвшинд гарна. 2017 онд банкны системийн хуульд эрс өөрчлөлт хийнэ. Тухайлбал, Монголбанкны тухай хуульд өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулж байгаа. Үүнд ОУВС-гийн мэргэжилтнүүд ирж зөвлөгөө өгсөн. 1994 онд батлагдсан Валютын зохицуулалтын тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны хуулийг шинэчлэн найруулах, Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэх тухай хуулийг олон улсын стандартад нийцүүлнэ" гэсэн юм.

Мэдээлэлтэй холбогдуулан УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлэв. Тухайлбал, УИХ-ын гишүүн З.Нарантуяа "Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэхэд багагүй ажил хийсэн байна. Энэ хүрээнд аль салбарын, ямар компанийг дэмжиж ажилласан бэ" хэмээн тодруулав. Харин Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан "Төв банк чиг үүргийнхээ дагуу арилжааны банкуудтай хамтран ажиллаж, хяналт тавьдаг. Аж ахуйн нэгжүүдээс зээл, тусламж хүссэн өргөдөл өдөр бүр ирдэг. Гэхдээ Монголбанк зээл олгодоггүй тул одоогоор шийдвэрлээгүй байгаа" гэсэн хариулт өглөө. Мөн УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан "2015 онтой харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ 45 хувиар нэмэгдсэн байна. Энэ хэмжээгээр эдийн засаг агшиж байна гэсэн үг. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2017 онд хэдэн хувьтай байхаар төсөөлж байгаа вэ. Бид валютыг экспорт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтаас олдог. Одоо Монгол, БНХАУ-ын гадаад харилцааны асуудлаас үүдэн 1.7 тэрбум ам.долларын своп хэлцлийн хугацааг сунгах эсэх нь тодорхойгүй болоод байна. Тэгэхээр гадаад орчны эрсдлээ яаж тооцоолж байгаа вэ" гэлээ. Үүний хариуд Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан "Монголбанк 2017 онд эдийн засгийн өсөлт 0-1 хувь байна гэж тооцоолжээ. Харин гадаад орчны асуудал ярих бол байнгын хорооны хуралдааныг хаалттай горимд шилжлүүлэх хэрэгтэй. Энэ бол эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой хэмээн" гэв.

Гишүүдийн зүгээс эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг дараа нь хаалттай хуралдаж, хэлэлцэх хэрэгтэй гэсэн санал хэлж байлаа. Төв банкны зүгээс хаалттай хуралдаан хийсэн тохиолдолд бүх мэдээллээ дэлгэрэнгүй өгөх боломжтой хэмээв.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

**Ерөнхий эрхлэгч:** С.ГАНТОГОО

**Орлогч эрхлэгч** Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

**Хариуцлагатай нарийн бичгийн дарга:** Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

**Ахлах редактор:** Б.ӨНӨРТОГТОХ 88006842

**Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба** Н.ПУНЦАГБОЛД 88096454

**Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:** Б.ӨНӨРТОГТОХ 88006842

**Гэрэл зургийн алба:** Г.АРГУУЖИН 96017873

**Компьютерийн алба:** Б.ГАНЗОРИГ 99998796

**Маркетинг, зар сурталчилгааны алба:** Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

**Захиалга, борлуулалтын алба:** М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

**Дугаарыг эрхэлсэн** Н.ПУНЦАГБОЛД

*Улсын бүртгэлийн дугаар: 907300528*
*Индекс: 100757*

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс:**
**976-70113551**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

МЭДЭЭЛЭЛ

## Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх хуулийн өргөн мэдүүлэв

УИХ-ын дарга М.Энхболдод өчигдөр Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслүүдийг УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт өргөн мэдүүллээ. Аль ч улсын төрт ёсны шударга байдлын шалгуурт эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг шийдвэрлэх тогтолцооны шударга байдал чухал байр суурь эзэлдэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүний халдашгүй байх эрхийг хангах, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах, шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх зэрэг зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэх үүднээс Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулсан гэж Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт онцлов. Хуулийн төслийг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны сайн туршлага, олон жилийн практикаар шалгагдсан хэм хэмжээнүүдийг уламжлан авч үлдэх, бусад орны эрүүгийн процессын хуулийг судалж дэвшилтэт зохицуулалтыг харгалзах, Монгол Улсын нэгдэн орсон холбогдох олон улсын гэрээ конвенцийн заалт, НҮБ-аас ирүүлсэн зөвлөмжүүдэд нийцүүлэх чиглэлээр боловсруулсан юм байна. Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн юм. Өнөөгийн байдлаар манай улсад зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч субьектууд болон тэдний эрх, үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээг Захиргааны хариуцлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиас гадна Гаалийн тухай, Татварын Ерөнхий хууль, Өрсөлдөөний тухай зэрэг салбар тус бүрийн хуулиар зохицуулж байгаа юм байна. Энэ байдал нь хуулийн давхардал,хийдэл,зөрчлийг бий болгож, улмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг харилцан адилгүй хэрэгжүүлэх, журмаар хүний эрхийг хязгаарлах зэргээр хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхагдахгүй байх Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрхийг хангах явдал гажуудах нөхцөлийг бүрдүүлж байна гэж Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт хэллээ.

ШАР МЭДЭЭ

### Б.Дэлгэрсайхан гишүүн хандив өгчихөв үү эсвэл..



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Эдийн засагч Б.Осоргарав гэдэг хүн нэг гэнэт л хэвлэлийн бага хурал зарлаж, улсын өрийг дарахад хувь нэмрээ оруулж, 10 сая төгрөг, алтан бөгж, 10 адуу бэлэглэсэн билээ. Улмаар ард түмнийг хандив өргөхийг уриалсан. Бүр тооцоо хүртэл гаргаад, нэг иргэн боломж бололцоондоо тааруулаад тэдэн төгрөг өгвөл өр төлж хүрнэ гээд л мэдээлсэн. Тэгвэл энэхүү мэдээллийн маргааш нь УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан мөн л мэдээлэл хийж, хувиасаа 100 сая төгрөг хандивласан. Мөнгөтэй хүн аргагүй л зангарагтай загнав хэмээн магтах хүн олон байлаа. Гэвч зарим эх сурвалжийн мэдээлж буйгаар Б.Дэлгэрсайхан гишүүн зүгээр ч нэг 100 саяыг тавиад туучихсан юм биш гэнэ. Хөшигний ард энэхүү аяныг эхлэлийг нь томоохон тавиад, оронд нь "Төмөр зам"-ын 30 хувийг түүнд өгөхөөр тохироо хийсэн гэх бор шувуу нисээд эхэллээ. За дээрээс нь Б.Дэлгэрсайхан, Н.Оюундарь нарын гишүүд хамтдаа хурал хийж, хандивыг дэмжсэн нь энэ мэт таамаглалыг батлаад ч байх шиг.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

## Өвлийн спортынхонд битүү ордон л хэрэгтэй байна

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Тэшүүрийнхэн гэхэд Хандгайт хавьд шаардлагад нийцэхээргүй тавьсан мөсөн дээр л бэлтгэлээ хийдэг. Ядаж байхад бэлтгэл хийх хугацаа нь ч гэсэн баг. Хоккейчид ч ялгаагүй, зуны бэлтгэлээр л бүх зүйлээ нөхөж яваа. Ийм байхад төр засгаас бага ч болов анхаараад, нэг битүү ордон бариад өгчихгүй гүрийсээр л. Үеийн үед энэ асуудал том сэдэв болдог. Нэг дарга гарч ирээд л өвлийн битүү ордон барина гээд л ярьдаг. Одоо ч гэсэн яригдаж л байгаа. Сая хоккейчид дэлхийн аваргаас хүрэл медаль хүртээд ирэхэд ч өвлийн спортыг дэмжинэ гэж ярьж л байна. Яаж ч дэмжих гээд байгаа юм. Уг нь яаж ийж зүтгэж байгаад нэг ордон бариад өгчихвөл тэшүүр, хоккей, шорт-трек, уран гулгалт гээд маш олон спорт хөгжих боломжтой. Биеийн тамир, спортын газрын дарга Ц.Шаравжамц спортын төв ордонг шинэчилнэ, зээлээр бариулна гээд л байгаа даа. Тэгэхээр манайд боломж байхгүй биш байгаа. Гагцхүү өвлийн спортыг дэмжих сэтгэлтэй хүн энэ төр засагт, эрх мэдэлтнүүдийн дунд алга. Уг нь манай хоккейчид шайбтай хоккейн ДАШТ-д оролцох боломж байгаа. Гэтэл мөсөн ордонтой байх шаардлага тавьдаг учраас жийгдээд л хоцорч байна. Өнөөдөр хоккейн тамирчид аргаа барахдаа “Бидэнд шагнал энэ тэрээс илүү мөсөн ордон хэрэгтэй байна шүү дээ” хэмээн ярьсан байсан. Хэрвээ мөсөн ордонтой, байнгын бэлтгэлтэй болчихвол манай хоккейчид дэлхийд өрсөлдөж чадахаар байна.

Түүнээс гадна тэшүүрийн ганц нэг гайгүй тамирчид маань гаднаас санал ирвэл явна гэж байгаа. Угаас Монголд бэлтгэл хийх ч орчин алга болохоор хангамж сайтай, тогтмол бэлтгэл хийж болохоор газар руу явахыг хүсэлгүй л яахав. Хэрвээ гадагшаа явчихвал манай тамирчид хангалттай амжилт үзүүлнэ, дэлхийн хэмжээнд өрсөлдөж чадна.

Тэр үед нь “Энэ тамирчин манайх” гээд л шүүрс алдаад сууж байж ч магадгүй. Тийм болохоор яаж ийж байгаад нэг ордон барих л хэрэгтэй байна. Өвлийн спортын төрлөөр манайхан амжилт гаргах боломж бүрэн байна шүү дээ. Тамирчид хангалттай харууллаа. Одоо жаахан л дэмжээд өгмөөр байна. Ер нь манай аль ч спортод дэмжлэг дутуу байгаа. Гэхдээ өвлийн спортод бол бүр ямар ч дэмжлэг алга. Ядаж байхад ордонгүй. Уг нь төр засгийнхан жаахан сэтгэл гаргаад, хөөцөлдөөд, асуудлыг шийдье гэвэл болохгүй, бүтэшгүй зүйл уг нь бишсэн.

# Тэд биднийг “ТАХИА АНХДАГЧ УУ, ӨНДӨГ АНХДАГЧ УУ” гэдэг болох уу гэж байна

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**




### Akipress: Монголчууд ОУВС–ийн зээл бүтнэ гэдэгт итгэлтэй байна

Олон улсын валютын сангийн төлөөлөгчид 2016 оны сүүлчээр Монгол Улсын нийслэл Улаанбаатарт айлчилж, холбогдох Засгийн газрын албаны хүмүүстэй уулзаж, эдийн засгийн нөхцөл байдалтай танилцсан. Тэд аравдугаар сарын 21-ээс арваннэгдүгээр сарын 4 хүртэл тэнд ажиллаад 2017 оны эхээр дахин очихоор шийдвэрлэсэн. Энэ дагуу өнгөрсөн сарын 20-нд Олон улсын Валютын сангийн төлөөлөгчид Улаанбаатарт буух төлөвлөгөөтэй байсан ч, мөн сарын 30 хүртэл хойшлогдож, зарим төлөөлөгчид нь 31-ний өдөр ирсэн гэнэ. Монгол Улсын Сангийн сайд Б.Чойжилсүрэн хэлэхдээ “ОУВС-ийн төлөөлөгчид болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр эцсийн шатандаа орсон. Бид хоёрдугаар сарын 15-ны дотор ОУВС-ийн төлөөлөгчидтэй гэрээнд гарын үсэг зурах болов уу” гэж ярьжээ. Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бондын эргэн төлөлтийн хугацаа дуусах гуравдугаар сараас өмнө тус гэрээнд гарын үсэг зурснаар санхүүгийн асуудал нь хөнгөрөх юм. Мөн Б.Чойжилсүрэн сайд “Засгийн газарт хоёр, гурван ч сонголт байгаа. Ямар ч байсан бид бондын эргэн төлөлтөө хийж чадна гэдэгтээ итгэлтэй байна” гэжээ.

### dailymail.co.uk: Хөрөнгө оруулагчид ОУВС–ийн зээл бүтэх эсэхийг анхааралтай ажиглаж байгаа

Монголчууд ирэх сард 600 сая орчим ам.долларын бондын төлбөрийг барагдуулахын тулд Засгийн газартаа тусалж, бэлэн мөнгө, алтан бөгж, тэр ч байтугай аргамаг хүлгээ хүртэл хандивлаж эхэлжээ. Зах зээл дэх түүхий эдийн үнэ унаж, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч, гадаадын хөрөнгө оруулалт буурсны улмаас тус улсын эдийн засаг хямарч, бэлэн мөнгөний гачигдалд ороод байгаа юм. Одоогийн байдлаар тус улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгийн ханш өнгөрсөн оны мөн үеэс бараг дөрөвний нэг хүртлээ сулраад байна. Тус улсын Засгийн газар Олон улсын валютын сан болон БНХАУ-аас зээл авахаар яриа хэлэлцээр хийж байгаа. Гэвч 580 сая ам.долларын бондын эргэн төлөлтөө хугацаанд нь барагдуулж чадахгүй байж магадгүй хэмээн хөрөнгө оруулагчид санаа зовниж байна. Хонконгод төвтэй нэгэн худалдаа эрхлэгч “Хэрвээ Монгол Олон улсын валютын сангийн Стэнд бай хөтөлбөрт хамрагдаж, шинэ бонд гаргах нөхцлийг бүрдүүлж чадахгүй юм бол бондын өрөө эргэн төлөх эх үүсвэрээ хаанаас олох юм бэ. Нөгөө тахиа анхдагч уу, өндөг анхдагч уу гэдэг шиг л зүйл болно биз дээ” гэж ярьсан байна. Хэдийгээр олон тооны мал сүргээ алдаж ч магадгүй зуд нүүрлэж, төрөөс үзүүлэх халамж багасч, хүнсний бүтээгдэхүүн, шатахууны үнэ өссөн ч, нэр бүхий эдийн засагчид, парламентын гишүүд ард түмний хандивын аяныг зарласны дараа энгийн иргэд хувиасаа хандив өргөж эхэлжээ. Аж ахуйн нэгжүүд, хууль тогтоогчид хүртэл хувиасаа 100 сая төгрөг хандивлаж байна. Зээлжих зэрэглэлийн “Fitch” агентлаг Монголын гадаад валютын нөөцийг сүүлийн долоон жилийн хугацаа дахь хамгийн доод түвшинд хүрсэн хэмээн үнэлсэн байдаг. Тэгвэл “Legal & General Investment Management” компанийн зах зээлийн стратегич Симон Куйжано өнөөгийн үүсээд буй нөхцлийг “Гадаад валютын нөөц маш бага хэмжээнд хүрсэн нь Монголын хамгийн том асуудал болж байна. Үнэн хэрэгтээ хөрөнгө оруулагчид ОУВС-ийн зээл бүтэх эсэхийг л анхааралтай ажиглаж байгаа” хэмээсэн байна. Мөн тэрбээр




“Мэдээж Монголд санхүүжилт босгох өөр сонголтууд байгаа. Гэхдээ төр засгийн ойлгомжгүй хувирамтгай байдлаас болоод тэдгээр сонголтууд ч тодорхойгүй байна” гэж онцолсон байх юм.




### Mainichi.jp: Монголчууд алтан бөгж, аргамаг хүлгээ хандивлаж байна

600 сая орчим ам.долларын үнэт цаасны эргэн төлөлтийн хугацаа нь дөхөж буй улсаа аврах зорилгоор Монголын жирийн иргэд бэлэн мөнгө, алт, аргамаг хүлэг тэргүүтнээ улсдаа хандивлаж эхэлжээ. Эдийн засаг нь хямарч, улсаас үзүүлэх нийгмийн халамжаа танаж, өргөн хэрэглээний бараа, шатахууны үнэ нь нэмэгдэж, ард иргэдийн амьдрал хүндэрч буй эсэхийг үл харгалзан нэр бүхий эдийн засагч, парламентын зарим гишүүд хандивын аян эхлүүлжээ. Аян эхлээд маш богино хугацаа өнгөрсөн ч, их хэмжээний санг бүрдүүлж чадсан байна. Харин тус улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат ирэх сард эргэн төлөх бондын өрийг барагдуулах шийдлийг олсон хэмээгээд хандивыг өөр ажилд зориулна гэдгээ мэдэгдсэн байх юм. Тэрбээр энэ сарын 1-нд хийсэн мэдэгдэлдээ “Ард түмний хандивын аяныг зогсоох боломжгүй. Засгийн газар хандивын мөнгийг эрүүл мэнд, боловсрол, утааг бууруулах болон, нийтийн эзэмшлийн дэд бүтцийг сайжруулахад зориулахаар шийдвэрлэсэн” гэж хэлсэн байна.

### Globaltimes.cn: БНХАУ Монголд тусалж чадна

Ирэх сард Монгол Улс бондын 580 сая ам.долларын зээлээ эргүүлэн төлж чадах эсэх талаар зарим шинжээчид байр сууриа илэрхийлж, “Худалдааны гол түнш нь болох БНХАУ Монголтой эдийн засгийн хамтын ажиллагаагаа сайжруулж чадвал тус улс санхүүгийн мухардмал байдлаасаа гарч, эдийн засаг нь аажимдаа сэргэнэ” хэмээн дүгнэж байна. Гадаадын зарим хэвлэлд бичсэнээр Монголчууд хувиасаа Олон улсын валютын сангаас авах зээлийн мөнгө орж ирэх хүртэл хугацаа хожих зорилгоор Засгийн газартаа үнэт эдлэл, бэлэн мөнгө, тэр бүү хэл агт морьдоо хүртэл хандивлаж буй ажээ. Үүнд Монголын нэр бүхий эдийн засагч, парламентын гишүүд нэгдэн түүчээлж буй талаар орон нутгийн хэвлэлд мэдээлсэн нь бий.

2012 оны гуравдугаар сард Монголын хөгжлийн банкнаас таван жилийн хугацаатай, 5.75 хувийн купонтой үнэт цаас гаргасан бөгөөд ирэх сарын 21-ний өдөр бондын хугацаа дуусах учиртай. Гэвч хэдхэн жилийн өмнөх хоёр оронтой тоонд хүртлээ өсч байсан ДНБ нь огцом унаж, эдийн засгийн хямралд өртсөн Монгол Улсын Засгийн газарт Олон Улсын валютын сан болон БНХАУ-аас зээл авахаас өөр гарц үлдээгүй тухай хэвлэлүүд мэдээлсээр байгаа юм. Хэвлэл мэдээллийнхэн ийн санаа зовниж байгаа бол Монголын Засгийн газар өрөө бүрэн төлөхөө илэрхийлж байгаа. Монголын Сангийн яамнаас Засгийн газар бүх өрөө төлнө гэдгийг хөрөнгө оруулагчдад баталсан бол нэгдүгээр сарын 20-нд Монголын Хөгжлийн банкны албан ёсны вэб сайтад ч гуравдугаар сарын 21 гэхэд 580 сая ам.долларын өрөө бүрэн төлж дуусгах хангалттай чадвартай байгаа тухай мэдээлэл нийтлэгдсэн байлаа. Албаныхны хэлж буйгаар Олон улсын валютын сангийн Стэнд бай хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаархи хэлэлцээр эерэг үр дүнтэй үргэлжилж буй бөгөөд тун удахгүй тохиролцоонд хүрнэ гэсэн хүлээлт үүссэн аж. Тийм ч учраас Монголын Засгийн газар өөр гарц одоогоор хайх бодолгүй байгаа нь илэрхий. Гэтэл шинжээчид Монголын хамгийн том түнш БНХАУ өрийн хямралд өртсөн тус улсыг өрийн дарамтаас аврахад чухал үүрэг гүйцэтгэх боломжтой гэж дүгнэж байна. Хятад, Орос, Төв Азийн орнуудын харилцааны шинжээч Сун Хуйжун “Глобал Тайм сандэй”-д өгсөн ярилцлагадаа “БНХАУ-ын хөрш орон эдийн засгийн хямралд өртсөн. Хятад шаардлага гарсан үед нь л найз гэдгээ харуулах хэрэгтэй” гэж ярьжээ. Тэрбээр “Хятад засгийн газар хоорондын гэрээ байгуулан зээл олгох эсвэл олон талт хамтын ажиллагаатай байгууллагуудаас бага хувийн хүүтэй зээл олгох замаар Монголыг аварч чадна” гэдгийг онцолсон байна. Монгол Хятад хоёр улсын хоорондын худалдаа 2016 онд 8.27 тэрбум ам.доллар гарсан бөгөөд энэ нь өмнөх жилээс 2.3 хувиар буурсан үзүүлэлт юм. Бээжингийн их сургуулийн Евроази судлалын төвийн захирал Ли Шинг “Хятадад Монголыг өнөөгийн хямралаас нь гаргаж, эдийн засгийг нь сайжруулах хүчин чадал бий. Гэхдээ одоо тохиромжтой үе нь биш” гэжээ. Тэрбээр “БНХАУ-




ын санаачилсан “Нэг бүс, нэг зам” санаачилгын дагуу эдийн засгийн коридор Монгол, Оросыг дамжин өнгөрөх юм. БНХАУ-аас гаргасан энэ төлөвлөгөөг Монгол эерэгээр ашиглах боломж бий” гэж ярьжээ.

2013 онд “Торгоны зам, эдийн засгийн бүслүүр” болон “21 дүгээр зууны далайн торгоны зам” санаачилгыг санал болгож байв. Энэ дагуу “Эдийн засгийн коридор дагуух дэд бүтэц, бүтээн байгуулалтын олон төлөвлөгөөнүүд биеллээ олбол Монголд их хэмжээний ашиг авчирна” гэж мөн ярьсан байна. “Торгоны зам”-ын хойд чиглэлийн маршрутад Монгол, Казахстан, Орос гэсэн гурван улс маш чухал оролцоотой билээ. Түүнчлэн цааш нь тэрбээр “580 сая ам.долларын өрийг Хятадын тусламжтайгаар маш хялбар дарах боломжтой. Гэвч Хятад хэлэлцээрийн бус зарчмыг баримталдаг” гээд өнгөрсөн жил Далай лам Монголд айлчилсантай холбоотойгоор хоёр улсын харилцаанд сэв суусныг онцолсон байх юм. Гэхдээ Монголын Гадаад хэргийн сайд Далай ламыг дахиж урихгүй гэдгээ илэрхийлсэн билээ.

# ДЭЛХИЙ

# Б.АССАДЫН ДЭГЛЭМ 13 МЯНГАН ХҮНИЙГ ЦААЗАЛСАН







**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэр дагуу тус шоронд 2011-2015 оны хооронд нэг долоо хоногт хамгийн багадаа нэг удаа ихдээ 50 хүний бүрэлдэхүүнтэй хэсэг хүмүүсийг цуглуулан гаргаж, улмаар эрүүдэн шүүх маягаар хүчирхийлснийхээ дараа "яг шөнө дундын үед нууцаар дүүжлэн" хөнөөх цуст аллага явагдаж байжээ. Тайланд "Эрүүдэн шүүлтээс цааз гүйцэтгэл хүртэлх процессыг аваад үзэхэд, хоригдлуудын бүгдийнх нь нүдийг боосон байдаг төдийгүй хоолойд нь олс углах хүртэл тэд өөрсдийг нь алах гэж буй болон хэрхэн хөнөөх гэж буй талаар юу ч мэддэггүй" гэж бичсэн байна. Мөн хохирогчдын ихэнх нь өнөөгийн Ерөнхийлөгч Башар ал Ассадын дэглэмийг эсэргүүцэгчид буюу энгийн иргэд байсан гэнэ. Эмнести энэ мэт цаазын ял гүйцэтгэл нь дайны гэмт хэрэг төдийгүй, хүн төрөлхтөний эсрэг гэм нүгэл хэмээн тодорхойлжээ.

> ...Сирийн Засгийн газар баривчлагдсан хүмүүсийг бөөнөөр нь устгаж буйн зэрэгцээ хоол хүнс, ус, эм тариа өгөлгүй залхаан цээрлүүлж, "бөөнөөр нь устгах" үйл ажиллагааг хэрэгжүүлж байна хэмээн мөн шүүмжилсэн байгаа юм. Хамгийн гол нь энэ мэт аймшигт аллага эдүгээ ч үргэлжилж байх магадлалтай гэж үзэж буйгаа илэрхийлсэн байлаа...

Сирийн Засгийн газар баривчлагдсан хүмүүсийг бөөнөөр нь устгаж буйн зэрэгцээ хоол хүнс, ус, эм тариа өгөлгүй залхаан цээрлүүлж, "бөөнөөр нь устгах" үйл ажиллагааг хэрэгжүүлж байна хэмээн мөн шүүмжилсэн байгаа юм. Хамгийн гол нь энэ мэт аймшигт аллага эдүгээ ч үргэлжилж байх магадлалтай гэж үзэж буйгаа илэрхийлсэн байлаа. Дамаск хотоос хойш 30 км-т байрлах Саяднаяа шоронгийн үйл ажиллагааг цэргийнхэн хянадаг бөгөөд тус шорон улсынхаа хамгийн том хорих байгууламж гэнэ.

Эмнести өмнө нь Сирид 2011 оны гуравдугаар сард иргэний дайн эхэлснээс хойш Засгийн газрын зүгээс явуулсан баривчилгааны үеэр амиа алдсан хүмүүсийн тоо нийтдээ 17700 байжээ. Харин тус шоронд 13 мянган хүн нас барсан нь нийт нас барагсдын ихэнхийг эзэлж байгаа нь Эмнести интернэшнлийн дээрх дүгнэлтийг бататгаж буй хэрэг бололтой.

## Шинзо Абэ Д.Трамптай уулзана

Японы Ерөнхий сайд Шинзо Абэ ирэх бямба гараг буюу хоёрдугаар сарын 10-ны өдөр Вашингтонд очиж АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трамптай уулзахаар болжээ.

АНУ-ын шинээр томилогдсон Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон, Японы Гадаад хэргийн сайд Фүмио Кисида нар энэ уулзалтын өмнө утсаар ярилцсан тухай Kyodo агентлаг мэдээллээ. Төрийн нарийн бичгийн дарга болон Гадаад хэргийн сайд хоёр улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ярилцсан бөгөөд Хятад-Японы хооронд маргаантай байгаа Сэнкакү арлын асуудлаар АНУ Японы байр суурийг дэмжинэ хэмээснийг онцолсон байна. Ерөнхийлөгч Трампыг тангаргаа өргөсний дараа Ерөнхий сайд Шинзо Абэ мөн утсаар ярьсан бөгөөд Япон улсын аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлэхээ Трамп нотолсон юм.

## БНХАУ-ын анхны зорчигч тээврийн онгоц тун удахгүй нислэг үйлдэнэ

БНХАУ-ын анхны үндэсний үйлдвэрийн "С919" дугаартай зогчигч тээврийн онгоц энэ оны эхний хагаст анхны нислэгээ үйлдэхээр төлөвлөжээ. Энэ талаар орон нутгийн мэдээллийн агентлагууд дамжуулж байна. "People's Daily" сонинд бичсэнээр "С919" дугаартай зогчигч тээврийн онгоцонд холбогдох систем тоног төхөөрөмжийг бүгдийг нь суурилуулж дууссан бөгөөд нэгдүгээр сараас зургадугаар сар хүртэлх хугацаанд багтаж "тэнгэрээр нисэх мөрөөдлөө биелүүлэхээр" төлөвлөжээ. "С919" зорчигч тээврийн онгоцыг БНХАУ-ын "COMAC" компани үйлдвэрлэжээ. Тус компани анхны үндэсний үйлдвэрлэлийн зорчигч тээврийн онгоцныхоо анхны нислэгийг 2015 онд багтааж хийхээр төлөвлөж байсан ч, туршилтын нислэг, нэмэлт тоноглол гэх мэт шалтгааны улмаас хойшилж, мөн оныхоо арваннэгдүгээр сард угсралт нь бүрэн дууссан байдаг. "С919" онгоц нь 168 зорчигчийн суудалтайажээ.БНХАУЕвропын агаарын тээврийн томоохон компани Эйрбус, АНУ-ын Бойнг зэрэг онгоцны хэрэглээгээ бууруулж, зорчигч тээврийн онгоцны зах зээлд өрсөлдөхүйц хэмжээний онгоц бүтээх ажилд сүүлийн найман жилийн турш анхаарлаа хандуулж иржээ.

## Бэлэн мөнгөөр тооцоо хийвэл торгоно

Энэтхэгийн эрх баригчид энэ оны дөрөвдүгээр сарын 1-нээс эхлэн 300 мянган рупи болон түүнээс дээш хэмжээний бэлэн мөнгөөр тооцоо хийсэн ямар ч хэлцлийг гэмт хэрэг гэж үзэн торгууль ногдуулах шийдвэр гаргажээ. Энэтхэгийн засгийн газрын татвар хураамж хариуцсан түшмэл Хасмукх Адхиагийн ярьснаар, торгуулийн хэмжээ нь хүлээн авсан мөнгөн дүнтэй тэнцүү байх аж. "Жишээ нь, та 400 мянган рупигийн бэлэн мөнгөөр мэс засал хийлгэсэн байлаа гэхэд торгууль нь 400 мянга байна, хэрвээ хэлцэл таван саяынх бол торгуульд нь таван саяыг төлөхөөс аргагүй болно. Торгуулийг таван саяыг хүлээн авсан хүнд ногдуулна. Хэрвээ худалдан авагч дэлгүүрээс үнэтэй цаг аваад мөнгөө бэлнээр төлсөн бол торгуулийг нь дэлгүүрийн эзэн төлнө" гэж Адхиа тодотгон тайлбарлажээ.

Түүний хэлснээр, энэхүү арга хэмжээ нь авлига, шударга бусаар олсон орлоготой тэмцэхэд чиглэсэн байна. Авлигатай тэмцэх энэхүү арга хэмжээ нь өнгөрсөн оны арваннэгдүгээр сард 500 болон 1000-тын мөнгөн дэвсгэртүүдийг эргэлтээс хассанаас эхэлсэн засгийн газрын явуулж буй бодлогын үргэлжлэл юм. Бэлэн мөнгөний хомсдол нь иргэдэд ихээхэн хүндрэл учруулж байгаа ажээ. Харин эрх баригчдын хувьд, эдгээр хатуу чанд арга хэмжээ нь авлигыг зогсооход тус дөхөм болно гэж үзэж байгаа юм.

# Ирээдүйн эрчим хүчийг нээх ЭКСПО-2017



Х.БАТЖАРГАЛ

Казахстаны нийслэл Астана хотод зохиогдох "Экспо-2017" хүртэл таван сар хүрэхгүй хугацаа үлджээ. "The New York Times" –ын 2017 оны онцлох үйл явдлын жагсаалтад 26 дугаарт эрэмбэлэгдсэн тус экспод одоогоор 112 улс орон, олон улсын 18 байгууллага оролцох хүсэлтээ ирүүлжээ.

Хэдийгээр энэхүү арга хэмжээ ихээхэн хэмжээний хөрөнгө санхүү шаардах ч дэлхий дахины анхаарлыг татсан том үйл явдал болж байна. Өөрөөр хэлбэл, Казахстан улсын хөгжлийн илэрхийлэл болж байгаа юм. Нэгэн үе газрын тосны орлогоос хамааралтай байсан улс одоо эрчим хүчний экологийн эх булагт түшиглэсэн эдийн засаг бүхий болж өөрчлөгдөж байна "Экспо-2017" үзэсгэлэнг зохион байгуулах зөвлөлийн дарга Ерлан Сыдыков тус үзэсгэлэн нь олон талын ач холбогдолтойг тэмдэглэж хэлсэн байна. Тухайлбал, тус улсын аялал жуулчлалын салбарын хөгжилд үлэмж өсөлт гарах юм. Экспо-ийн үеэр зохион байгуулагчдын зүгээс зочид, жуулчдад "Байконур"сансрын хөлгийн буудалтай танилцуулах хөтөлбөр гаргажээ. Дэлхийн анхны сансрын буудалтай танилцах аялалын хөтөлбөр жуулчдын анхаарлыг татах нь дамжиггүй юм.

"Экспо-2017" зохион байгуулах ажлын хүрээнд томоохон бүтээн байгуулалт, төслүүдийг хэрэгжүүлжээ. Олон улсын павилонууд бүгд баригдаж нийт 130 оролцогчдод хүлээлгэн өгөөд байна. Орчин үеийн шийдэл бүхий мэдээлэл харилцааны төв ашиглалтад ороход бэлэн болжээ. Энэ төвийн дотор үйлчилгээний болон мэдээлэлийн медиа төв багтаж байна. Тансаг зэрэглэлийн түрээсийн байр, зочид буудлууд баригдаж дуусч байгаа бөгөөд үзэсгэлэнгийн дараа орон сууц болох ажээ.

Зохион байгуулагчдын үзэж байгаагаар "Экспо-2017" бол хямралын эсрэг арга хэмжээ юм. Тухайлбал, үндэснийхээ үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор бүх мужийн удирдлага, аж ахуйн нэгжийнхэнтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулжээ. Үүний үр дүнд 322 үндэсний үйлдвэрлэгчдээ татан оролцуулсан бөгөөд тэдэнтэй нийт 48.9 тербум тенге буюу 150 сая ам.долларын гэрээ байгуулжээ. Энэ төслийн хүрээнд тус улсад нийт тавин мянган ажлын байр шинээр бий болсон байна. Мөн Казахстан улс 126 сая еврогийн санхүүжилтийг авч, 211 тэрбум тенге буюу 660 сая ам.долларыг хөрөнгө оруулалтаар босгож чаджээ.

Экспо-2017-ийн уриагаар "Ирээдүйн эрчим хүч" гэсэн сэдэвт нэр сонгож авсан бөгөөд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн асуудал дэлхийн олон улс, корпорацийн сонирхлыг татаж байгаа энэ үед хамгийн оносон хувилбар болсон гэж судлаачид үзэж байгаа юм. Энэ талаар Казахстаны ерөнхийлөгч Нурсултан Назарбаев "Казахстан улсыг олон зүйлээр дэлхий мэднэ, Тухайлбал эрчим хүчний үйлдвэрлэл, уран олборлох цар хэмжээгээр нь, амуу тарианы том экспортлогч гэдгээр нь мөн байгалийн асар их нөөц бүхий баялагаар нь мэднэ. Тэгвэл одоо бид өөрийн орны ирээдүй рүү чиглэсэн тэмүүллийг харуулах хэрэгтэй байна" гэж онцлон тэмдэглэсэн байна. Энэ удаагийн экспогийн гол чиглэл нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй холбоотой учраас энэ чиглэлийг ихээхэн хөгжүүлж, судалдаг Номхон далайн Холбооны улсууд Астанагийн үзэсгэлэнд ач холбогдол өгч байгаа ажээ. Жишээлбэл, Чили улс уул уурхайн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж байгаа хэдий ч нарны болон салхины хүчийг ашиглаж эрчим хүч үйлдвэрлэж байгаа нэг орон юм. Перу улс бол усан цахилгаан станц ихтэй, байгалийн хийх үлэмж нөөцтэй хэдий ч нар, салхи болон газрын гүний дулааныг ашиглаж цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чиглэлийг их хөгжүүлж байгаа. Харин газрын тос чамгүй ихээр олдборлодог Мексик улс ч гэсэн эрчим хүчний ирээдүйн хөгжил, шинэ төрлийн эрчим хүчний нөөц бололцоог сонирхож байгаа юм. Дэлхийн энэ бүс нутагт сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлээр дэлхийд тэрүүлэгч Коста-Рика улс орщдог. Коста-Рика улс өөрийн эрчим хүчний хэрэглээний 90 хувийг альтарнатив буюу бусад эрчим хүчний эх үүсвэрээс гаргаж авдаг ажээ. Олон улсын эрчим хүчний байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга Винсенте Лоссерталес "Бидний гол зорилго бол сонирхол татах үзэсгэлэн зохион байгуулж Казахстан улс болон түүний ард иргэд, Астанад ирсэн гадаадын зочин хүмүүсийг баярлуулах, урам зориг бэлэглэх асуудал юм. Энд ирсэн хүмүүс өөртөө гурван нээлт хийнэ. Нэгд, Казахстанд орон гайхамшигтай сайхан орон, хоёрт Астана бол мөрөөдлийн гэмээр сайхан тал нутгийн хот, эцэст нь "Экспо-2017" эрчим хүчний шинэ эх үүсвэрийн боломжийг эндээс мэдэж авах болно" гэжээ.

Даяарчлалын хүрээ хэмжээнд зохиогдож буй энэ том үйл явдал Казахстан улс руу дэлхийн жуулчдыг татан авчирна гэдэгт итгэлтэй байгаагаа "Астана ЭКСПО-2017" үндэсний компанийн аялал жуулчлал, ирээдүйн хөгжлийн салбарын орлогч захирал Роза Асанбаева илэрхийлж байв. Тус улсын ерөнхийлөгч Нурсултан Назарбаев энэ үзэсгэлэн яармагт гадаад улс орнуудын шинэлэг, иноваци бүхий технологийг өөрийн улс орондоо нутагшуулж ашиглахыг эрмэлзэх хэрэгтэй гэж онцлон хэлсэн байна.

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out

# АРД ТҮМЭН ИРГЭДЭЭС ХАНДИВ АВАХЫГ ДЭМЖИХГҮЙ БАЙНА




З.МӨНХСУВД
Б.АЛТАНБАГАНА

Монгол Улс ирэх гуравдугаар сарын 21-ний дотор Хөгжлийн банкны 580 сая ам.долларын өрийг төлөх ёстой. Харин энэ өрийг хэрхэн төлөх нь тодорхойгүй байгаа бөгөөд зарим иргэд ард түмнийг хандив өгөхийг уриалаад байгаа билээ. Мөн Сангийн яам хандивын данс хүртэл нээчихээд байгаа юм. Харин энэ талаар иргэд ямар байр суурьтай байгааг сонирхсон юм.



### Л.Ганболд : Бид хоногийн хоол, өдрийн унааны мөнгөө яая гэж байна

*/Сонгинохайрхан дүүргийн иргэн/*

-Тэр тэнэгүүд улсын хамаг мөнгийг “идчих”-ээд, ард түмнээр төлүүлэх үү, ёстой үгүй шүү. Төрөөс төрсөн тэрбумтан гээд нэгнийхээ улыг шагайж, өөрсдийнхөө булхайг өөрсдөө гаргаж, идэж ууснаа зарлаад байхад энэ өрийг төлөх хүн нь тодорхой байна. Яахаараа бид төлөх ёстой гэж. Тэр хүмүүс нь төлөх ёстой биз дээ. Хоногийн хоол, өдрийн унааны мөнгөө яая гэж байхад. Одоо цагт хөдөлбөл хөлс, зогсвол зоос болчихоод байхад амьдрах гэж ядаж байгаа ард иргэдээ ингэх шаардлага байхгүй л баймаар юм. Манайх шиг их баялагтай улс үүнийгээ түшиглээд, зөв зохицуулаад явбал хямрал гэдэг зүйлийг мэдэхгүй л амьдарна даа. 2008 оноос эхтэй одоогийн энэ хямрал энгийн иргэд бидэнд хамгийн их нөлөөлж, ард түмний ахуй амьдрал хүндхэн байна. Идэж, уугаад цатгалан байгаа хэсэг бүлэг томчууд ч үүнийг ойлгохгүй л дээ.



### Э.Ганбаатар: Ахиад зээл, бонд авахгүй гэсэн баталгаа алга

*/Чингэлтэй дүүргийн иргэн/*

-Мөнгөтэй хүн ховор болсон цагт улсдаа өгөх нь битгий хэл үр хүүхдээ цатгалан өсгөхөд хүндхэн байна. Дээр үед солонгосчууд алтан ээмэг, бөгжөө улсдаа хандивлан, өрнөөс гарч байсан гэж ярьдаг. Харин одоогоор бид алтан ээмэг, бөгж битгий хэл зэсээ ч зүүж чадахгүй байна шүү дээ. Улсын маань хэдэн хувь нь амьжиргаагаа аргацааж, хэчнээн нь хэт баян амьдралтай билээ, үүнийг бодолцох хэрэгтэй. Мөн өмнө нь байсан их өрийг Орос тэглэсэн. Тэр үед их өрийг тэглэчихвэл эдийн засаг ахиж унахгүйгээр сэргэнэ гэж л байсан. Энэ удаагийн өрийг дарахад иргэн хүний хувьд улсынхаа төлөө гээд нэг удаадаа өөрийн чадахаараа хандив үзүүлж болно. Гэхдээ хандив цуглуулаад дарлаа гэж бодоход, цаашдаа зээл, бонд авахгүй гэсэн баталгаа алга байна. Хэдхэн жилийн дараа хэдэн арван тэрбумаар нь ахиад өр тавьчихвал бас л иргэдээсээ гуйгаад суух уу.



### Ш.Даваа: Ард иргэдийн амьдралаар тоглож байгаа хүмүүст хариуцлага тооцох хэрэгтэй

*/Баянзүрх дүүргийн иргэн/*

-Үнэхээр улс орныхоо төлөө гэвэл тусламж үзүүлнэ. Харин улсын мөнгийг хэрэггүй зүйлд зарцуулж, эх орноо хямралд оруулсан хүмүүсийн өр, зээлийг бид төлөх ёсгүй. Өөрсдийнхөө үр хүүхдийг сургууль соёлд сургах гэж хамаг байдгаа барж байна. Ийм үед иргэдээсээ мөнгө төгрөг авна гэж юу байх вэ дээ. Ард иргэдийн амьдралаар тоглож байгаа хүмүүст хариуцлага тооцох хэрэгтэй. Ийм улс оронд амьдрахад үнэхээр хэцүү байна. Төр засгийг удирдаж байгаа хүмүүс буруу бодлого явуулснаас болж өрөнд орсон. Зөв бодлого боловсруулж, ажлаа зөв төлөвлөж чадсан бол ийм байдалд хүрэхгүй. Ер нь манай улсын дийлэнх иргэдэд хямрал нүүрлэсэн. 10 хүрэхгүй хувь нь баян чинээлэг, дутах юмгүй амьдарч байгаа байх. Ядарсан иргэдээ амар тайван байлгаж болдоггүй л юм байх даа.



### С.Гүндсамбуу: Баячуудын нуусан хөрөнгийг гаргаж өрөө төлөх хэрэгтэй

*/Сүхбаатар дүүргийн иргэн/*

-Эдийн засгийн хүнд байдалд өртсөн хүмүүс бол ард иргэд. Үнэхээр хүссэн хүмүүс нь цөөхөн хэдэн төгрөг өгөх л байх. Иргэдээсээ мөнгө цуглуулж, эдийн засгаа сайжруулна гэдэг юу л бол. Оффшор дансанд нуучихсан баячуудын хөрөнгийг ил гаргах хэрэгтэй. Улсын хөрөнгийг идсэн хүмүүсээс мөнгөө буцааж авсан тохиолдолд л өр зээлээсээ салах боломж бүрдэнэ. Хүн болгон хандив өргөж чадахгүй. Амьдралын боломжоотой хэдэн хүн л өгнө. Ард иргэдээсээ тусламж аваад, өр, зээлээсээ салсан жишээ Солонгост байсан. Тэр туршлагыг авч хэрэгжүүлж болно. Гэхдээ мөнгө төгрөг цуглуулахаасаа өмнө төрийн луйварчдаасаа салах хэрэгтэй. Тэгж байж л ард иргэд сайхан амьдарна. Үнэхээр улс орныхоо төлөө гэвэл миний зүгээс хандив өргөхөд бэлэн байна.



### Л.Нэргүй: Үүнийг би тийм ч зөв санаа гэж бодохгүй байна

*/Хан-Уул дүүргийн иргэн/*

-Төр засагт ажиллаж байгаа, баян хүмүүсийн хувьд хандив өргөхөд болохгүй юм байхгүй байх. Харин мань мэтийн тэтгэврийн хэдээрээ амьдралаа залгуулдаг хүмүүс юугаа ч өгөх вэ дээ. Үүнийг би тийм ч зөв санаа гэж бодохгүй байна. Эдийн засаг үнэхээрийн доройтоод, шалдаа буучихсан юм алга. Харин дээгүүрээ зохицуулалт буруу хийж, өмнө хойдохоо бодохгүй, муу удирдаж байгаа учраас л одоогийн энэ байдалд хүрсэн гэж боддог шүү. Гэхдээ шаардлага гарвал эх орондоо тусламж үзүүлэхэд хэзээд бэлэн. Хамгийн чухал нь манай улсад хандив тусламж биш зөв бодлого, сайн удирдлага хэрэгтэй байгаа байхгүй юу.



### Д.Амгалан: Зөв зүйлд зарцуулж чадвал хандив өгнө

*/Сүхбаатар дүүргийн иргэн/*

-Бүх иргэдээс тусламж үйлчилгээ гуйж, улсаа өрнөөс салгаж чадна гэвэл тэтгэврийн бид тав, арван төгрөгөө хандивлалгүй яахав. Харин олсон мөнгөө хэрэгтэй зүйлд зарцуулж байна уу гэдэг л чухал. Ард иргэдээс мөнгө аваад, өөр зүйлд зарцуулж байвал хэн ч тусламж үзүүлэхгүй. Тийм боломж бололцоо ч бидэнд байхгүй. Бүх иргэдээ хамруулж, зөв зүйлд зарцуулж чадвал миний хувьд ч гэсэн тусламжийн гараа сунгахад бэлэн байна.



### Ё.Цэцгээ: Тусалж чадахгүй байж битгий лай бол л доо

*/Сонгинохайрхан дүүргийн иргэн/*

-Ард иргэдээсээ хандив авч, хямралаас гарна гэсэн асуудал байхгүй шүү дээ. Биднээс болж хямраагүй байж тусламж авна гэж юу гэсэн үг вэ. Ард иргэд бид чинь төрийн томчуудаас ч илүү хүндхэн байдалд байгаа. Эхлээд тэр баячуудаасаа, бидний хураалгасан мөнгийг “идсэн” төрийн өдөрлөгүүдээс нэхээд, дараад нь иргэдээсээ асуух нь зүйн хэрэг. Ард түмний амьдрал хүндхэн, чадах ядахаараа болгож байхад нь тусалж чадахгүй байж битгий лай бол л доо.

### С.Батбаатар: Тэдний ууж идсэн өрийг бид төлөх нь утгагүй

*/Чингэлтэй дүүргийн иргэн/*

-Миний таньж мэддэг хүмүүсээс НӨАТ-ийн буцаан олголтын мөнгөө улсдаа хандивласан, дөрвөн сая төгрөг өгсөн гэж дуулдаж л байсан. Гэхдээ бид яагаад өгөх ёстой гэж. Дээгүүрээ идэж, ууж, дуусгаж байгаа томчууд нь төлөөгүй байхад тэдний тавьсан өрийг бид төлөөд сууж байна гэдэг утгагүй байгаа биз дээ. Тэр их мөнгийг үнэхээр хэрэгтэй зүйлд нь, цаг тухай бүрт нь зарцуулаад явсан бол ийм их өр гарч ирэхгүй л байх байсан. “Идэж” болно гэхдээ бас хэмжээгээ мэдэж байх хэрэгтэй. Тэрбум төгрөг байхад талыг нь “идээд”, талаар нь юм хийж болно доо.



### С.Лутсайхан: Улсынхаа төлөө гээд зайлшгүй шаардлага гарвал хандив өгнө

*/Дундговь аймгийн иргэн/*

-Мал дээр бүх насаа өнгөрөөсөн хөдөөний малчин надаас хандив гуйвал малаасаа л өгөх байх. Өөр өгчихмөөр юм үнэндээ байхгүй. Уг нь хандив нэрийдлээр өөрсдийнхөө хувьдаа ашигласан мөнгөө төлүүлэх гэж хичээх нь буруу зүйл л дээ. Цагийн юмыг цагт нь, зориулах ёстой зүйлд зориулсан бол урд хормойгоороо хойдохоо нөхөх шаардлага байхгүй. Гэхдээ улсынхаа төлөө зайлшгүй өгөх ёстой, зөв зүйлд хэрэглэх бол хүнээр хэлүүлэлтгүй хэдэн малаа би өөрөө тууж очоод өгчихнө.



### Б.Баасанжав: Үүнийг би дэмжиж чадахгүй

*/Чингэлтэй дүүргийн иргэн/*

-Яагаад луйварчдын “идсэн” мөнгийг ядарсан бид төлөх ёстой гэж. “Идсэн” хүмүүс нь ард иргэдээ урдаа барьж, шархаа нөхүүлье гэж бодож байгаа. Үүнийг би дэмжиж чадахгүй. Ядарсан иргэдээ зулгааж , мөнгө төгрөг гуйна гэдэг ямар ч улс оронд байж болохгүй. Манайх шиг байгалийн баялаг ихтэй улс орон хаана байгаа юм. Энэ баялгаа зөв зүйлд зарцуулж чадахгүй, хувьдаа завшсанаас болж ийм нөхцөлд хүрсэн. Ард иргэдээ бодох хэрэгтэй байна. Өдрөөс өдөрт л амьдрал хэцүүдэж байна шүү дээ. Үсээ зулгааж олсон мөнгөө луйварчдын тавьсан өрөнд өгч чадахгүй.

## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Ядуу Монголын ядарсан сэтгэлгээгээр тоглож буй

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тиймээс бид энэ удаагийнхаа “Дугаарын сурвалжлага” буландаа сүлжээний бизнес буюу олон улсын санхүүгийн луйварчид манай улсыг “бай”-гаа болгон сонгоод үйл ажиллагаагаа нь өдрөөс өдөрт хэрхэн өнгө орж цэцэглэж байгаа талаар хөндөж байна. Манай улс шиг эдийн засгийн хямралтай, бэлэн мөнгөний хомсдолд орсон улсад хамгийн хурдан баяжих арга бол сүлжээний бизнес байдаг байна. Тиймээс ч энэ төрлийн бизнест гаршсан олон улсын санхүүгийн луйварчид ядуу, буурай болон эдийн засгийн хямралд орсон улсыг “Бай"-гаа болгодог. Мэдээж энэ “шалгуурт” нь бэлэнчиллэх сэтгэлгээгээр баян, ядуу монголчууд нэн сайн тохирсон нь ойлгомжтой. Тэгвэл сүүлийн үед иргэдийн олон нийтийн сэтгэл санаагаар бүрэн “наадаж” чадаж байгаа сүлжээний бизнес бол Казакстаны ядуурлыг бууруулах төсөл гэх сайхан нэртэй G-TIME \ golden time\ гэх сүлжээний бизнес юм байна. Энэхүү сүлжээг дагаж “далдагнах” хүмүүсийн хэлж буйгаар “ядуурлыг бууруулах төсөл” гэх шидэт төсөл нь дэлхийн 77 оронд үйл ажиллагаа явуулдаг, үйлдвэрлэгч компани гэх юм билээ. Гэтэл хачир дээрээ өнөөх Казакстан улсад нь ч ийм үйл ажиллагаа эрхэлдэг төв байдаггүй гэнэ.

Тэгвэл энэхүү ядуурлыг бууруулах бус ядуурлыг эрчимтэй нэмэгдүүлэх залилангийн бизнесийг манай улсад ОХУ-ын иргэд оруулж ирсэн байх юм. Харин гардан үйлдэж байгаа монгол хүн нь Эрдэнэцогтын Оюунчимэг гэх эмэгтэй байна. Тэрбээр телевизэд мөнгө төлж мэдээ бэлтгүүлээд “Манай компани дэлхий дээр номер нэг цэвэр экологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрлэгч. Өөрийн бүтээгдэхүүнийг борлуулахын тулд дэлхийн зах зээл дээр гишүүнчлэл элсүүлдэг. Энэ бол 21 дүгээр зууны суут худалдааны бизнесийн хэлбэр юм. Өнөөдрийн байдлаар манай компаниас олон гишүүд маш өндөр хэмжээний орлого олсон” хэмээн магтан суух юм билээ. Тиймээс өдөр, шөнөгүй надад мөнгө өгнө гээд зүтгээд байгаа цахим ертөнцийн найз нараасаа мэдээлэл авахаар шийдсэн юм. Тиймээс ч миний бие “G-time MGL” гэх 100 гаруй мянган гишүүнтэй сүлжээний бизнесийнхээ талаар хамаг л нарийн нандин зүйлээ ярьдаг, бичдэг фэйсбүүк группт гишүүнээр “заларчихлаа”.

### Амьдралаа ломбардаад сүлжээчин болсон л гэнэ

Фэйсбүүк, твиттер хуудаснаас “та хуримтлалын хөтөлбөрт 135 мянган төгрөгөөр ороод хэдхэн сарын дотор 25 сая төгрөгтэй болохыг хүсвэл аргыг нь заагаад өгье. Мэдээлэл авах нь “ок” гээд коммент үлдээгээд явчихъя”. Аль эсвэл “Өнөөдөр цалингаа авлаа. 500 ам.доллар. Шууд орж ирж байна. Хамтраад сайхан баг болоод ажиллая” гэх сайхан үгтэй, ам.долларын зурагтай, үнэхээр дансанд нь их хэмжээний мөнгө шилжин орсон зурвасны зураг дүүрэн байх болсон. Мэдээж эдгээр мэдээллийг орж хараагүй, уншаагүй хүн ховор. Уг нь эдгээр сүлжээний бизнесүүд хуурамч бөгөөд иргэдийг залилж байгаа талаар цагдаагийн газраас удаа дараа анхааруулга, сэрэмжлүүлэг өгч байгаа. Гэсэн хэдий ч тус сүлжээнд итгэсэн хүмүүсийн тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр... Мэдээж миний элсэн орсон “G-time MGL” фэйсбүүк группын бүх найзууд доороо элсүүлэх хоёр хүнээ хэрхэн олох, яаж мөнгө олох гээд бүх аргын талаар ярилцаж өнждөг боллоо.

Тэр бүү хэл, зарим төрийн албан байгууллага, томоохон худалдааны төвийн худалдагч нар эд хөрөнгөө барьцаалан зээлдүүлэх газарт тавиад, цалингаа маш олон сараар зээл авч тус сүлжээнд элсэн орж байх юм билээ. Тиймээс ч тус сүлжээнд орохын тулд “G-time MGL” фэйсбүүк группын найз эгч “Э”-ээс хэрхэн сүлжээнд элсэн орсон талаар асуусан юм. Гэтэл тэрбээр “Эгч нь найзынхаа урилгаар сургалтад суусан юм. Тэгээд л тэтгэвэр авдаг надад олдохгүй боломж юм байна гэж бодсон. Тиймээс хашаа, байшингаа ломбарданд тавиад л сүлжээчин болсон доо. Харин доороо хоёр дүүгээ оруулах гээд машинаа зарчихсан. Гэтэл манай хоёр дүү хүнээ олохгүй байна. Одоо харин яах вэ...” гээд л яагаад ийм их үнээр сүлжээчин болж байгаа юм бол гэж гайхмаар зүйлийг ярьж гарсан юм. “Э” эгч маань сүлжээний бизнес нь дампуурахын цагт орох орон, оочих аягаггүй л болох бололтой. Өөрөөр хэлбэл, хүмүүс гэнэт их мөнгөтэй болох хүсэлдээ хөтлөгдөөд амьдралаа ломбардаад сүлжээчин болсон байх юм. Энэхүү сүлжээнд хамгийн идвэхтэй элсэн орогчид нь “Нарантуул” худалдааны төвийн түрээслэгчид байх юм билээ. Тиймээс бид манай улсын хамгийн олон хүн цуглардаг “Нарантуул” худалдааны зах дээр энэхүү сүлжээнд элсэн орсон хүмүүс хэрхэн ядуурлаас гарч баяжиж байгааг сурвалжлахаар тус төвийг зорилоо.

### Мөнгөтэй болж баяжих биш өртэй болж шаналж сууна

“Нарантуул” зах сар шинийн баярын гоёл болон бэлгээ авах гэсэн хүмүүсийн хөл, хөдөлгөөнд дарагджээ. Тэр дундаа дээл болон бүс барааны хэсэгт хүмүүс хоорондоо зөрөлдөх зайгүй шахам байлаа. Эхлээд миний бие туршлага дутаж нэлээд олон хүнээс тус сүлжээний талаар асуулаа. Хамгийн хачирхалтай нь тус захын зарим худалдагчид “Жи тайм” сүлжээний тухай мэдэхгүй гэж байхад нөгөө хэсэг нь “Манайхнаас “Жи тайм”-д элссэн хүмүүс бий. Зарим нь элсээд хүнээ олчихлоо л гэж байсан. Зарим нь хүн олдохгүй байна. Чи элсчихээч гэж л байсан. Гэхдээ энэ талаар би ярьмааргүй байна. Яах вэ, зүгээр сонирхуулаад хэлэхэд, “Жи тайм” сүлжээнд элссэн мэр сэр хүмүүс бий” гэдэг хариултыг хэлж байв. Ийнхүү хэсэг явж даарсаны эцэст жаахан дулаацах санаатай нэгэн утас цэнэглэдэг ТҮЦ-рүү орсон юм. Гэтэл ...

“Баяраа ах ерөөсөө хүнээ олохгүй юм. Би бүр өөрөө нэг хүнийх нь мөнгийг өгөөд оруулж өгч байхад. Дахиад нэг хүнээ олчихож чадахгүй арчаагүй юм аа. Би ч “Жи тайм”-ынхаа мөнгийг олчихсон л доо. Одоо яах вэ. Ямар хэцүү юм бэ” хэмээн 30 орчим насны эмэгтэй хамт ажилладаг хүмүүстэй бухимдуухан ярив. Тэгтэл “Одоо нэг хүн олчихвол тэр ядаргаатай хүмүүсээс баг хуваагдаад салчихна. Тэгвэл ёстой амар байна. Хэдүүлээ хурдан явъя. Одоо сургалт эхлэх болж байна” хэмээн бас нэгэн эмэгтэй өгүүлсэн юм. Гэтэл өөр бас нэг нь “Тэгээд хүнээ олоогүй байж очиж яах юм. Хүнээ олоод л очсон нь дээр биз дээ” хэмээн бухимдан ярилаа. Тэдний яриаг сонсохнээ би сохорсон биш завшив гэгчээр хайгаад байсан “Жи тайм”-ынхан дээр ороод ирсэн хэрэг. Тэдгээр хүмүүст үндсэн ажил нь болох үс засах, гар утас борлуулах ажил нь сонин биш болсон нь илт. Харин түүний оронд “одоо яах вэ, яах вэ” гэх ямар нэгэн зүйлд зовж, шаналсан эмэгтэйчүүдийн яриа өрнөж байлаа. Тэдний зарим нь хүнээс мөнгө зээлж сүлжээнд орох мөнгөө олсон гэнэ. Гэвч доороо хоёр хүнээ элсүүлж чадаагүйгээс болж, тавьсан зээл нь нэхэгдэж эхэлжээ. Тэдний сүлжээнд орох болсон гол шалтгаан нь 8000 ам.доллар. Багахан мөнгө гаргаад гэр орныхоо амьдралыг дээшлүүлэх гэсэн санаанаасаа болж ийм байдалд хүрчээ. Эдгээр эмэгтэйчүүдийн ийнхүү зовж шаналах болсон шалтгаан нь өнөөх шидэт ядуурлыг бууруулах хөтөлбөр. Тэдний дунд “Жи тайм” сүлжээнд орохын тулд мөнгө хүүлэгчдээс “Нөхөр маань солонгос гарах гэж байгаа юм. Виз нь гарчихаар эргүүлж өгнө” хэмээн худал хэлж их хэмжээний мөнгө зээлсэн нэгэн ч байв. Харин одоо өөрийнхөө доор хүн элсүүлэх, мөнгө хүүлэгчдийн “мөнгөө өг” гэх дуудлагаас болж өдөр бүр сэтгэлийн дарамттай явах болжээ. Эдгээр эмэгтэйчүүд зөвхөн нэг жишээ нь. Өөр хэчнээн хүн өндөр хүүтэй зээл авч нойргүй хоножь, мөнгөтэй болж баяжих биш өртэй болж шаналж суугааг таашгүй. Бүсгүйчүүдийн ярианаас сургалт явуулдаг байр нь хаана байдгыг мэдэж авсан юм. Тиймээс манай сурвалжлах хэсэг сургалтад хамрагдаж, тодорхой мэдлэгтэй болохоор “Жи тайм”-ын нэгэн оффисыг зорив.










### “Жи тайм” бол сүлжээний бизнес биш гэнэ үү

Хотын төвийн А зэрэглэлд байрлах нэгэн тохилог байранд “Жи тайм” сүлжээний сургалт явагдана. Манай сурвалжлах хэсгийг очиход аль хэдийнэ сургалт эхэлсэн байлаа. Сургалтын танхим хоёр хэсгээс бүрдэх бөгөөд шилэн хаалгаар хуваагдана. Шилэн хаалганы цаана 10 орчим хүн суух бөгөөд сургалтад оролцогчдыг ажиглаж байгаа харагдав. Харин хаалганы наана 40 орчим насны нэгэн эмэгтэй “Жи тайм”-ын талаар хүмүүст тайлбарлах бөгөөд өөртөө тун итгэлтэй ярих аж. Учир нь тэр “Жи тайм” сүлжээнд нөхөртэйгөө хамт элсэж, гурван ч удаа 8000 ам.долларыг авч чадсан гэнэ. Түүнийг энэ тухайгаа хэлмэгц сургалтад ирсэн хүмүүс нэгэн зэрэг алга ташиж, “Ямар гоё юм бэ. Баяр хүргэе” хэмээн уулга алдацгаав. Сургалт явуулж буй эмэгтэй цааш яриагаа үргэжлүүллээ. Тэрбээр, орифлэйм, эвон зэрэг сүлжээнд явж байсан гэнэ. Гэхдээ тэдгээр сүлжээнүүд хэзээ ч өөрт нь оффисын зардлын мөнгийг



# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

өгч байгаагүй аж. “Жи тайм”-ын бусдаас ялгарах онцлогын нэг нь оффисын зардал. Оффисын зардал гэж хоёр сая 683 мянган төгрөг орсон бөгөөд түүнийгээ доороо ажилладаг хүмүүстэйгээ хувааж авчээ. Тэр сургалтынхаа төгсгөлд “Олон удаа 8000 ам.долларыг авах болтугай” хэмээн тун ч итгэлтэй хэлнэ. Харин энэ үед сургалтад суугчид “Ямар гоё юм бэ. Элсмээр юм байна” гэхээс өөр “Би чинь доороо яаж хүн элсүүлэх билээ. Хаанаас хүн олох вэ. Одоо гар дээрээ их хэмжээний бэлэн мөнгөтэй хүн бий бил үү” гэдэг талаар огтхон ч бодохгүй шууд л 8000 ам.доллартай болох юм шиг бодож, сэтгэж буй нь үйлдэл, үг бүрээс нь илэрхий байв. “Жи тайм”-ын сургалт явуулж байгаа гишүүд нь ч амархан 8000 ам.долларыг авчихсан юм шиг ярьж, илтгэцгээж байв. Тэдний хамгийн түрүүнд хэлдэг үг нь “Жи тайм” бол сүлжээний бизнес биш. Казакстаны ядуурлыг бууруулах хөтөлбөр юм. Харин гадуур “Жи тайм”-ын нэрийг ашиглаж иргэдийг луйвардаж байгаа хүмүүс бий. Тэр хүмүүст л итгэж болохгүй гэх үг. Гэвч үнэн хэрэгтэй сургалтад нь суугаад, тэдний хэлж, ярьж буйг сонсвол “Жи тайм” бусдын адил сүлжээний бизнес л болж таарч байв. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад 1970-аад оноос хойш эхэлсэн пирамидыг ашигласан луйврын нэг аж. “Жи тайм” сүлжээ нь “Хуримтлалын”, “Үндсэн”, “Вип”, “Автомашины” гэсэн дөрвөн хөтөлбөртэй бөгөөд хөтөлбөр бүр өөр өөрсдийн гэсэн шаардлагатай.

## G-TIME

Тухайлбал, хуримтлалын хөтөлбөрт хамрагдахын тулд 120 мянган төгрөг тушаана. Харин түүндээ ОХУ-ын “Луч” болон “Михайл Москвий” брэндийн цагнаас сонгон авах боломжтой гэнэ. Тус хөтөлбөрийн барианаас гарахад 370 ам.долларын цалин авах бөгөөд 220 ам.доллараар дараагийн шат руу шилжих боломжтой ажээ. Мэдээж элдэв гоо сайхны бүтээгдэхүүн, цагны бонус бэлэгтэй. Харин “Вип” хөтөлбөрт хамрагдахын тулд багагүй мөнгө төлөх шаардлагатай. Энэ хөтөлбөр нь ихэвчлэн их мөнгө олох гэсэн хүмүүст зориулагджээ. Энэ хөтөлбөрт 500 ам.доллар буюу тухайн үеийнх нь ам.долларын ханшаас шалтгаалан монгол мөнгөөр хоёр сая 300 мянган төгрөг төлөх ёстой. Үүний дараа 8000 ам.долларын цалин авах гэнэ. Энэ мэтчилэн хөтөлбөр бүр өөрийн онцлогтой. Гэхдээ нэг л зүйл нь сүлжээний бизнес гэдгийг нотолж байв. Дээрх хөтөлбөрүүдэд хамрагдсан хүн бүр доороо хоёр хүн элсүүлэх ёстой. Доор элсүүлсэн хоёр хүн нь дахиад тус бүр хоёр элсүүлнэ. Гэх мэтчилэн явсаар таны доорх хүмүүс амжилттай ажиллаж чадвал та 8000 ам.долларын цалинд хүрч чадна. Хэрвээ доороо хүн элсүүлэхгүй, элссэн хүмүүс нь идэвхтэй хүн олж ирэхгүй бол таны тус компанид өгсөн 500 ам.доллар ямар ч үр ашиггүй болж, танд эргэж ирэхгүй. Ингээд л залилуулж байгаа нь тэр. Дээр өгүүлсэнчлэн пирамид хэлбэрийн сүлжээний луйврыг монголчууд бид аль хэдийнэ мэддэг болсон. Гэвч өнгө зүс, нэрээ өөрчилж гарч ирсэн сүлжээний луйварчдад итгэж, мөнгөө залилуулсаар байна. Тус сүлжээний сургалтад сууж байгаа ихэнх хүмүүс нь 20-50 насны эмэгтэйчүүд байсан юм. “Жи тайм”-д элссэн гишүүд дунд хоёулаа хамтарч элссэн тохиолдлууд ч бий гэнэ. Тодруулбал, “Вип” хөтөлбөрт элсэхэд шаардлагатай хоёр сая 300 мянган төгрөгийг хувааж төлөн нэг нэг хүн элсүүлэх үүрэгтэй аж. Энэ мэтчилэн иргэдийн толгойг угаасан явуулгын сургалтаараа дамжуулан өгч байв. Хэдий сүлжээний бизнес биш гэж хамгаалж байв ч доороо хоёр хүн элсүүлэх ёстой. Элсүүлсэн хоёр хүн чинь тус бүр дахиад хоёр хүн элсүүлэх ёстой гэсэн шаардлага нь сүлжээний луйврын бизнес гэдгийг батлаад өгч байсан юм. Энд “Жи тайм”-ын сургалт эхэлснээс хойш тус сургалтад суухаар ирсэн хүмүүс нэмэгдсээр байсныг онцолъё. Гэхдээ л нөгөө сэрэхгүй бол зүүд гоё оо гэдэг шиг. Сүлжээний бизнес биш. Үнэхээр ийм сайхан боломж олгодог төсөл байсан бол гоё оо гэчихмээр болтол сургалт явуулдаг гэдгийг сэтгүүлч миний бие мэдрээд гарч ирсэн гэдгээ хэлэхэд илүүдэхгүй биз ээ.

Бидний сурвалжлага хийж байгаатай давхцаад “Жи тайм”-ынхан шилдэг лидерүүдэд автомашин гардуулж өгөх ёслолын ажиллагаа нь “Улаанбаатар палас”-т болох талаар мэдэж авлаа. Ингээд бид машин авч буй шилдгүүдтэй уулзахаар ёслолын ажиллагаа руу явсан юм.

### Бүтээгдэхүүнээр далдалсан мөнгөн сүлжээ

Шилдэг лидерүүдэд автомашины түлхүүр гардуулж өгөх ёслолын ажиллагаагаанд бэлтгэж хун цагаан автомашинуудыг улаан туузаар чимэглэсэн байлаа. Уг ёслолын ажиллагаагааны үеэр “Жи тайм”-ын ерөнхий захирал Ж.Марат гэх нөхөр “Зөвхөн нэг удаа “Жи Тайм” корпорацийн бүтээгдэхүүн худалдан авснаар маш том хэмжээний шагнал урамшуулал авах боломжтой гэдгийг харж болно. Хэрэв та бидэнтэй хамтрахыг хүсвэл эхлээд компаниа судлаад, суралцаад, хоёр талын гэрээ байгуулснаар харилцан зөвшилцөж байж элсэн ордог. Түүний дараа компанийн бүтээгдэхүүнээ худалдан аваад, дараа нь бүтээгдэхүүнээ сурталчилж, өөрөөсөө хоёроос гурван гишүүн урьснаар амжилтад хүрэх боломж нээгдэж байгаа юм” хэмээн тайлбарлаж байлаа. Ийнхүү бүтээгдэхүүн “худалдан аваад” хэмээн тайлбарлаж буйн учир нь зүгээр л өнгөлөн далдлалт гэдэг нь ойлгомжтой байсан юм. Учир нь “Жи тайм” сургалтын төв дээр тухайн бүтээгдэхүүнийг нь бэлгэнд өгнө гэж ярихаас хоёр сая төгрөгөөр бүтээгдэхүүн худалдан аваад гэж огтоос ярихгүй байгаагаас бүх зүйл ойлгомжтой болж байлаа. Хэрвээ бүтээгдэхүүнээ зардаг байсан бол орифлэйм шиг бүтээгдэхүүнээ ярих л байсан биз дээ. Биднийг ийнхүү машины түлхүүр гардах ёслолд дээр саатах хооронд Монгол Улсын Засгийн газраас “Жи тайм”-тай холбоотой мэдэгдэл гараад амжив.

### Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Жи тайм”-тай ямар нэгэн байдлаар холбоогүй...

Эдийн засгийн хямралын эсрэг дэлхийн хэмжээний глобал төсөл хэмээн өөрсдийгөө хэлдэг “Жи тайм”-ын сургалтаар хүмүүсийн толгойг эргүүлэх хамгийн аймшигтай мэдээллийг өгдөг юм билээ. Тухайлбал, “Манайх сүлжээний бизнес биш. Ядуурлыг бууруулах хөтөлбөр. Монголын Засгийн газар ядуурлыг бууруулах “Жи тайм” хөтөлбөр дээр Казакстаны засгийн газартай хамтарч ажиллах харилцан зөвшилцөлдхүрчихсэн. Өнөөдөрбид “Машины хөтөлбөр”-т хамрагдсан гишүүддээ машиных нь түлхүүрийг гардуулж өгнө. Тэгээд амжвал өнөөдөртөө багтаад хэвлэлийн бага хурал хийнэ. Амжихгүй бол маргааш хийнэ. Тиймээс манай “Жи тайм” сүлжээний бизнес биш” хэмээн бүр төрийн нэрийг барьж иргэдийн толгойг эргүүлэх аж. Тэгвэл энэ талаар Монгол Улсын Засгийн газрын хэвлэл мэдээллийг хэлтсээс тодруулахад “Огт тийм зүйл яригдаагүй” гэдгийг тодотгоод давхар мэдэгдэл гаргасан юм. Мэдэгдэлд “Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Жи тайм” гэх санхүүгийн сүлжээтэй ямар нэгэн байдлаар огт холбоогүй. Энэ үйл ажиллагааг дэмжсэн ямар ч арга хэмжээнд оролцоогүй. Энэ талаар ямар нэгэн эерэг байр сууриа илэрхийлээгүй болно. Иймд олон нийтэд итгэл төрүүлэх зорилгоор энэхүү сүлжээндээ Монгол Улсын Ерөнхий сайдын нэрийг ашиглаж байгаагаа даруй зогсоохыг зарим нэр бүхий хүнээс шаардаж, баталгаагүй эх сурвалжийн энэ талын худлаа мэдээллийг цааш түгээж, иргэдийг төөрөгдүүлэхэд “хувь нэмэр”-ээ оруулахгүй байхыг сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон хувь хүмүүсээс хүсч байна. Дашрамд дурдахад, санхүүгийн пирамид бүхий энэхүү сүлжээ нь Монгол Улсын холбогдох хуулийг зөрчиж байгаа эсэхийг хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон цагдаагийн байгууллага шалгаж тогтоон ард түмэнд үнэн зөвөөр нь даруй мэдээлэх хэрэгтэй гэж үзэж байна. Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс” гэсэн байна.

Тус сүлжээний бизнест итгэж, онцгой олон хүн хуйлран орж буй томоос том хөшүүрэг нь төр засгийн нэр нүүр, төрийн тамга тэмдэг бүхий албан бичиг баримт гэдэг нь ойлгомжтой. Тиймээс бид энэ талын холбогдох байгууллагуудаас энэ асуудлаар тодруулсан юм.

### Зөвхөн гадаад худалдаа явуулах гэрчилгээ авсан

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй сүлжээний бизнес эрхлэгчдийн өөрсдийгөө хамгаалдаг нэг зүйл нь улсын бүртгэлийн гэрчилгээ юм. “Жи тайм”-д элссэн хүмүүс ч “Манайх албан ёсны үйл ажиллагаа явуулдаг. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй боллоо. Тиймээс та бүхэн бага мөнгөөр их мөнгө олж, машин, орон сууцтай болох боломжийг бүү алдаарай” гэх постыг фэйсбүүк, твиттерээр дамжуулан тараасан. Тиймээс манай сурвалжлах хэсэг уг гэрчилгээ ямар учиртай болохыг мэдэхээр Хуулийн этгээдийн улсын бүтгэлийн газрыг зорьсон юм. Бид энд ХЭУБГ-ын улсын бүртгэгч Б.Длэхсотой уулзаж, ярилцсан. Тэрбээр “Манайд 2016 оны арваннэгдүгээр сарын 18 онд 6123872 регистрийн дугаартай “Жи тайм корпорейшн” гэх гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани бүртгүүлсэн байна. Гишүүдийн тоо нэг гэж бүртгүүлсэн. Мөн үйл ажиллагааныхаа чиглэлийн гадаад худалдаа гэх чиглэлээр авсан байна. Бид сүлжээний талаар мэдэхгүй. Тэр талын зүйлийг хууль, хяналтын байгууллагууд мэднэ. Бид зөвхөн хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгодог” гэв. Мөн тэрбээр Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд энэ талаар заасан байдаг гэсэн юм. Тиймээс бид Аж нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийг судалсан.

Тус хуулийн 8.1.4 дүгээр заалтад Монгол Улсын нутаг дэвсгэрт олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно хэмээн заасан байна. Энэ мэтчилэн төрийн байгууллагын нэрийг барьсан тэдний үйлдэл зогсоогүй. Татварын цэнхэр дэвтрийг элсэн орсон хүн бүрт олгодог байна. Мэдээж манай байгууллага орлого олж байгаа татвараа төлнө гэхэд татварын байгууллага “Танай байгууллага сүлжээ байна. Тиймээс татвар авахгүй” гэж хэлэхгүй нь ойлгомжтой. Тиймээс албан ёсоор татвараа аваад цэнхэр дэвтрийг олгож л таараа. Мөн манай “Жи тайм” мэргэжлийн хяналтаар хүлээн зөвшөөрөгдсөн гэж хэлээд бас нэг тамга тэмдэг бүхий бичиг баримт харуулдаг. Тэгвэл мэргэжлийн хяналтынхан ч үүнийг өгөхгүй гэх шалтгаан байдаггүй байна. Учир нь тухайн сүлжээний бизнесийн оруулж ирж бэлгэнд өгдөг гэх гоо сайхны бүтээгдэхүүнийг нь шинжилж үзээд стандартад нийцсэн бүтээгдэхүүн байсан учир “Стандартад нийцсэн бүтээгдэхүүн байна” гэсэн баримт өгөх нь ойлгомжтой. Энэ мэт төрийн байгууллагуудын нэрийг барьж иргэдийн итгэлийг олох хөшүүрэг нь нэмэгдсээр байгаа нь харамсалтай. Тэгвэл өдрөөс өдөрт хохирох иргэдийн тоо өссөөр байгааг хараад суугаад байгаа учрыг асуухаар бид Цагдаагийн байгууллагыг зорьсон юм.

### ШӨХТГ, Эдийн засгийн зохицуулах хороо ажлаа хий

Гадаадын гэх тодотголтой сүлжээний бизнес эрхлэгч цөөн тооны хүмүүс улсын бүтгэлийн гэрчилгээгээр хаацаалан төрийн нэрийг барьж иргэдийг луйвардаж байгаа нь илэрхий байгаа энэ тохиолдолд цагдаагийн байгууллага юу хийж байгаа вэ. Энэ талаар тодруулахад “Одоогийн байдлаар “Жи тайм”-аас болоод хохирсон гэх иргэдийн мэдээлэл ирээгүй байна. Ер нь бид сүлжээний бизнесээс болж хохирч болзошгүй гэх сэрэмжлүүлгийг байнга хүргэж байгаа. Иргэд өөрсдөө л хянуур байх хэрэгтэй” гэсэн мэдээллийг өгсөн юм. Цагдаагийн байгууллага нь хохирсон иргэд гараагүй, тухайн сүлжээний бизнес нь албан ёсоор бүртгэлтэй болоод, татвар төлөөд үйл ажиллагаагаа явуулаад байгаа учир арга хэмжээ авч чадахгүй байж болох юм. Тиймээс ч өөрсдийнхөө эрх мэдлийн хүрээнд иргэдэд урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэж байгаа гэнэ. Тэгвэл манай улсад их наядаар тоологдох их хэмжээний мөнгө эргэлдэж байхад энэ мөнгө нь манай улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх эсэхийг яагаад судлахгүй байна. Энэ их мөнгөний урсгал хаанаас гараад ирэв, хаашаа урсаж байна, юунд ашиглаж байгааг уг нь Санхүүгийн зохицуулах хороо л зохицуулж баймаар юм. Гэтэл одоог болтол нүдэн балай чихэн дүлий байсаар л...

Хэрвээ их наядаар тоологдох энэ их мөнгөний бизнес олон олон хүнийг хямраагаад, Монгол Улсын эдийн засгийг хямраах ёстой нөгөө бужигнуулахаас урьдчилан сэргийлэх институт нь Санхүүгийн зохицуулах хороо. Хэрвээ “Жи тайм корпорейшн” гэх гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани хууль бус үйл ажиллагаа явуулж байгааг тогтоовол үйл ажиллагааг нь зогсоож хаах ч эрх мэдэл нь энэ байгууллагад байгаа. Түүнчлэн “Жи тайм”-д элсээд байгаа иргэд буюу хэрэглэгчдэд хамгийн ойр байх ёстой буюу тухайн компани хууль бус үйл ажиллагаа явуулж байгааг тогтоовол их хэмжээний мөнгөөр торгох цаашлаад үйл ажиллагааг нь зогсоож ч чадах эрх мэдэл бүхий өөр нэг институт ШӨХТГ юм. Тэгвэл тухайн байгууллага энэ чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулж байгаа талаар тодруулахаар манай сурвалжлах хэсэг ШӨХТГ-ыг зорьсон юм. Улмаар тус газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах газрын дарга Ц.Лхагвасүрэнгээс энэ талаар тодруулсан ч тоймтой хариу авсангүй. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчийн эрхийг хамгаалах газар нь лав сүлжээний бизнесээс болж иргэд хохирч болох эрсдэл үүсээд байхад мэдээгүй байгаа бололтой юм билээ. Харин Хамтын ажиллагааны газрын дарга Ш.Цэрэндулам даргыг цайндаа гарсан цагаас эхлээд 15:30 цаг хүртэл хүлээсний эцэст нэг уулзаж чадсан юм. Тэрбээр “Одоогийн байдлаар манай байгууллагад хохирсон гэх иргэний гомдол мэдээлэл ирээгүй байна. Гэхдээ бид урьдчилан сэргийлэх чиглэлээр танай сониноор дамжуулаад зөвлөмж хүргүүлмээр байна” гэсэн юм. Ийнхүү арга мухардсан бид тус газрыг орхин явахаас өөр арга байсангүй. Уг нь ШӨХТГ компани аж ахуйн нэгж байгууллагыг үйл ажиллагаа шударга явуулж байгаа эсэх, иргэдийг буюу хэрэглэгчдийг хохироож байгаа эсэхийг судалж, урьдчилан сэргийлдэг чиг үүрэгтэй байгууллага. Гэтэл энэ талын ажил хийгдэж эхлээгүй л байгаа бололтой байна. Ядуурлыг бууруулах бус улам хөөрөгдөх “Жи тайм” гэх сүлжээний бизнесийнхэний хэлсэн шиг “Нэг л өдөр би бахархалтайгаар “Би чадчихлаа” гэж орилох болно” гэдэг шиг иргэд маань эсэргээрээ хэдэн мянгаараа “Би шатчихлаа” гэж орилолдох цаг үед нь л арга хэмжээ авч эхлэх юм уу. Орсон борооны хойноос цув нөмөрдөг үйлдлээ хэзээ болох юм бэ.

---

**Аймгаас мэдээлж байна**

ОРХОН АЙМАГ




## “Шар тосны баяр”-ыг энэ сарын 19-нд тэмдэглэнэ

Оросын ард түмний өвлийг үдэж хаврыг угтдаг “Масленица” буюу шар тосны баярыг Эрдэнэт хотод энэ сарын 19-нд тэмдэглэх гэнэ. Энэ хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг Орхон аймгийн Засаг дарга, ОХУ-аас Эрдэнэт хотод суугаа Ерөнхий консул болон “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал хамтран гаргажээ. Мөн талуудын төлөөлөл багтсан ажлын хэсэг байгуулагдаж, тухайн өдөр зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байгаа аж. Төлөвлөгөөнд туссанаар “Масленица” буюу шар тосны баярын үеэр А.Амарын талбайд 20 орчим асар байгуулах юм байна. Эдгээр асарт “Москва Петушки” ресторан, 19-р сургууль, “Энэрэл” төв болон нийслэлд үйл ажиллагаа явуулдаг “Акутран” ресторон зэрэг байгууллагууд байрлаж Орос үндэстний хоолоор иргэдэд үйлчлэх аж. Мөн Монгол, ОХУ-ын ах дүүгийн найрамдалт харилцааг харуулсан урлагийн тоглолт, тэмцээн уралдаан зохион байгуулах бөгөөд энэхүү ажлыг “Уурхайчин” соёлын ордон, “Хангарьд” спорт ордон, Хүүхэд, залуучуудын театр хамтран зохион байгуулах юм байна.

## Мал бүхий иргэдэд өвс тэжээл олгож эхэллээ

Аймгийн Засаг даргын даваа гарагийн шуурхай зөвлөлгөөнийг Орхон аймгийн Засаг даргын орлогч С.Батжаргал, ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү нар удирдан явууллаа. Шуурхай зөвлөлгөөний үеэр хэд хэдэн чухал асуудлуудыг яригдаж, холбогдох газар, хэлтсүүдэд үүрэг, чиглэл өгч ажиллав. Тухайлбал, ногоон байгууламжийн төмөр хайс хашлага нь шовх үзүүртэй, иргэд, хүүхэд багачуудын амь нас эрүүл мэндэд аюул учруулж болохуйц байдалтай байна. Иргэн хальтарч унан хайс, хашлагын үзүүр, ирмэгт эрүүл мэндээрээ хохирсон тохиолдол ч гарсан. Эрдэнэт хотод 15000 метр орчим хайс байдгаас 5600 орчим нь шовх үзүүр бүхий төмөр хайс хашлага байдаг. Тэдгээрийн шовх үзүүрийг тайрч аюулгүй болгожээ. Цаашид 6800 гаруй метр газарт шар хуайс гэх мэт ургамал тарьж ногоон байгууламжийг хамгаалах ажил зохион байгуулахаар төлөвлөж байна. Баян-Өндөр сумын хувьд хонь, ямаанд цэцэг өвчний вакциныг тарих ажил ид үргэлжилж байгаа бөгөөд хөдөөгийн зарим чиглэлд цас орж, хөрлөж хатуурсан зэргээс шалтгаалан шатахуун зарцуулалт төлөвлөж байснаас нэмэгдэх төлөвтэй байгаа аж. Мөн зохих журмын дагуу 60 малчин өрхөд хямдруулсан үнээр 1232 боодол өвс, 610 шуудай тэжээл олгожээ.

Мал бүхий иргэдийн зүгээс “Малчин” багийг дахин байгуулах талаар хүсэлт нэлээд ирж байгаа бөгөөд энэ асуудлыг судлаж үзэхийг Баян-Өндөр суманд үүрэг болголоо. Түүнчлэн бичил хорооллуудын дунд, ялангуяа сүүдэр газруудын замын цас мөс зарим газарт цэвэрлэгдээгүй байгаа бөгөөд 2 дугаар сар гарснаас хойш явган хүн унаж бэртсэн 5 тохиолдол гараад байна. Иймээс Хот тохижуулах газар, Сууц өмчлөгчдийн холбоод, байгууллага аж ахуйн нэгжүүд өөрсдийн ойр орчмын 50 метр газрын цас мөсийг цэвэрлүүлэх үүрэг даалгавар өгч Хууль, эрх зүйн хэлтэс, Баян-Өндөр сумыг хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг үүрэг болгов. Мөн хорооллуудын тунд барилга обьект барих нэрийдлээр газар авсан ч өнөөг хүртэл ажил нь эхлээгүй, хашаа нь хотын өнгө үзэмж гутааж байгаа, нүх ухаж орхисны улмаас иргэд, хүүхэд багачууд унаж гэмтэх болзошгүй байгааг зэрэг газруудад хяналт шалгалт хийн, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг ЗДТГ-ын даргын зүгээс Барилга хот байгуулалтын газарт үүрэг болгов.

## Залуу малчин өрхийг 50 эм төлөөр дэмжинэ

“Монголын морин спорт, залуу уяачдын холбоо” өнгөрсөн сарын 31-ээс орон даяар залуу малчдаа дэмжих “Малжуулах хөтөлбөр” аян зарлажээ. Аяны зорилго нь залуу малчдаа дэмжиж цаашлаад хотын утаа, хэт бөөгнөрлийг бууруулахад чиглэж байгаа аж. Тодруулбал, хөдөө орон нутгийг хөгжүүлж малчдаа дэмжиж хотын хүүхэд багачуудыг хөдөөгийн ахуй амьдралтай танилцуулах гэнэ. Мөн аяны хүрээнд аймаг бүрээс нэг гэр бүл шалгаруулж 50 эм төлөөр дэмжих аж. Ингэснээр 21 айлыг малтай болгож хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжинэ гэж “Монголын морин спорт, залуу уяачдын холбоо”-ны Орхон аймаг дахь салбарын тэргүүн Б.Тэгшбаяр хэллээ. Уг хөтөлбөрт хамрагдах өрхийг тухайн орон нутаг дахь ХХААГ-тай хамтран тодруулах ажээ.

## Орхончууд монгол дээлээрээ бахархах өдөр болголоо

Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны арваннэгдүгээр сарын 16-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор 2017 оны нэгдүгээр сараас эхлэн сар бүрийг ИТХ-ын нэрэмжит болголоо. Энэ ажлын хүрээнд ИТХ-ын Нийгмийн хөгжлийн хороо хоёрдугаар сарыг “Төрөлх Орхон аймаг, түүх, соёл, уламжлал-Бидний бахархал” сэдвийн дор тэмдэглэнэ. Аяны зорилго нь Орхон аймгийнхаа түүх, соёлыг олон нийтэд түгээх, ёс заншил, өв уламжлалаа дээдлэхэд оршиж байгаа юм. Үүний хүрээнд энэ сарын 17-нд орхончуудыг “Монгол дээлээрээ бахархах”-ийг уриаллаа. Түүнчлэн ИТХ-ын ээлжит V хуралдаанд төлөөлөгчдийг монгол дээлтэйгээ ирэхийг ч сануулсан байна.

NO STRESS

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

# “Нүүдэлчдийн амьдрал”



Б.СУМЪЯА

Дэлхийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “Sony world photography awards-2016” наадмын мэргэжлийн гэрэл зурагчдын төрөлд тэргүүн байр эзэлсэн нэгэн бүтээлийг уншигчиддаа сонирхуулж байна. Тус наадмын мэргэжлийн төрөлд дэлхийн 10 гаруй орны чадвар, чансаатай мэргэжлийн гэрэл зурагчид 14 номинациар бүтээлүүдээ өрсөлдүүлж, Канадын уран бүтээлч Кэвин Фраэр хоёр ч номинацид шилдгээр шалгарсны нэг нь энэ зураг юм. Дээрх бүтээл “Хүмүүс” төрөлд тэргүүн байр эзэлжээ.

“Нүүдэлчин соёл устах нь” гэх гарчиг бүхий энэ зураг Кэвин Фраэрын Түвдийн уулархаг хэсэгт орших нүүдэлчдийн амьдралд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлт хийгээд албадан нүүлгэлт зэрэг асуудал хөндсөн цуврал зургийн нэг ажээ. “Дэлхийн дээвэр” гэгддэг хамгийн өндөрлөг, хамгийн уулархаг хэсэгт байрлах Түвдийн нүүдлийн соёл иргэншилт жирийн нэгэн малчны хүү, зурагт ийнхүү дүрслэгдсэн байна.

Энгийнээр харахад Монголын хөдөө хээр талд орших малчин айлыг санагдуулах хэдий ч, Түвдийн малчид нүүдлийн соёл иргэншлээ авч үлдэхийн тулд олон олон бэрхшээлийг тэсч гарсаар иржээ. Тодруулбал, тэд өдөр тутамдаа улстөрийн дарамт шахалтад өртөж, хүчээр нүүж шилжсээр ирсний зэрэгцээ нийгэм цаг үе, уур амьсгалын өөрчлөлт зэргээс үүдэн уламжлалт амьдралын хэв маяг нь аажим аажимаар устсаар буйг зурагчин дээрх цуврал зургаараа хөндсөн байна.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -12
Шөнө -24

Нөгөөдөр
Өдөр -9
Шөнө -22

Өдрийн зурхай

**ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААН БАР ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 08.10-18.03

**Үс засуулбал:** Өвчин эмгэг ирнэ



*Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/ Эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.*

Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Би Рина**

Хадам аав ёстой хөөрхөн. Сая

-Миний охин яагаад байна, бие нь өвдөө юу?

-Халуураад байна аа.

-Ханиад уу?

-Үгүй ээ, өчигдөр хүүгээсээ горьдчихжээ.

- Ээ аав нь тэгвэл орой хүүгээ авахдаа чамайг хуурах юм аваад ирэх үү гэнэ ээ. Мэдчихсэн юм чинь орой хуууртах уу, яах вэ. Ха ха ха.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ДУУЛГАХ СОНИН

## УИХ-ын гишүүн Б.Саранчимэг шатрын аварга болжээ

Сүүлийн үед УИХ-ын гишүүд тэр дундаа эмэгтэй гишүүдтэй холбоотой элдэв мэдээ цацагдах болсон. Харин тэгвэл нэгэн гэгээлэг мэдээ хүргэе. УИХ-ын гишүүдийн дунд болсон “Цэцэн түшээ” шатрын тэмцээн даваа гарагт болж, дүнгээ гаргалаа. Тэмцээний “Уран өрөг” шагналыг УИХ-ын дэд дарга, УИХ-ын гишүүн Ц.Нямдорж хүртэв. Тусгай шагналыг УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшин, Х.Болорчулуун нар авсан байна. Харин тэмцээний гуравдугаар байрт УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж, хоёрдугаар байрт УИХ-ын гишүүн Л.Энхболд шалгарч, тэргүүн байрыг УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, Г.Занданшатар нар эзэллээ. Өөрөөр хэлбэл, эмэгтэй гишүүдээсээ Б.Саранчимэг гишүүн авхаалж, сэтгэн бодох, стратеги тактик сайтай гэдгээ ийнхүү батлав. Тэмцээний нээлтийн үеэр УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон хэлсэн үгэндээ “УИХ-ын Тамгын газар Монголын шатрын холбоотой хамтарч зөвхөн УИХ-ын гишүүдийн аварга шалгаруулах шатрын тэмцээнийг энэ жил анх удаа албан ёсоор зохион байгуулж байна.

УИХ-д шатрын спортыг дэмждэг, хөгжүүлэхийн төлөө явдаг, тоглодог гишүүд олон бий. Оюун ухааны энэ спортыг хөгжүүлэхэд УИХ-ын гишүүд онцгой анхаарал хандуулж, идэвх санаачилгатай ажилладгийг дурьдахад таатай байна. Үе үеийн парламентын гишүүд хоорондоо тоглож, хэн нь мундаг вэ гэдгээ сорьцгоодог ч албан ёсоор аварга тодроогүй. Тиймээс албан ёсоор аваргаа шалгаруулах нь зүйтэй гэж үзсэн” гэв. Б.Саранчимэг дун сургуульд байхдаа онц сурдаг, шатар тоглодог байжээ.

## “Зөв мэндчилж сурцгаая” аян эхэллээ

Хүүхэд багачуудыг бага наснаас нь мэндлэх, хүндлэх ёсонд сургах, чин сэтгэлээсээ мэндчилж хэвшүүлэх, нийгмийн эрүүл харилцааг төлөвшүүлэх, хотын соёлтой ирээдүйн иргэдийг бэлтгэх зорилготой “Зөв мэндчилж сурцгаая” хэмээх аяныг эхлүүлжээ. Уг аяныг нийслэлийн Баянгол дүүргийн Засаг дарга С.Одонтуяа санаачилсан бөгөөд эдүгээ тус дүүргийн сургууль, цэцэрлэгүүдэд хэрэгжиж эхэлжээ. Өмнө нь хүүхдүүд ангидаа ороод ангийн багштайгаа мэндчилж өглөөг угтдаг байсан бол “Зөв мэндчилж сурцгаая” аян хэрэгжиж эхэлснээр өглөө бүр жижүүр багш нь хүүхдүүдээ хүлээн авч мэндчилдэг болсон байна.

